1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндэснэ хувь төрийн эрх мэдлийн хууль тогтоо, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд харилцан тэнцэртэй, хянагттай, би даасан бий зарчмын дагуу хаашилаа. Монгол Улсын түхэнд анх удаа шүүх эрх мэдэл нь Үндэснэ хуулийн дагуу бие дааж бусад эрх мэдлээс харахаас бус, тэдгээрийг хуулийн хурзэнд хянах, эрх мэдлийн хувьд тэнцэртэй, аливаа хэрэг, маргааны хянан шийдвэрлэх буртан эрх бүхий эрх мэдлийн эхийн тогтолцоотой болсон юм. Доктор профессор Б.Чимиджийн "... шүүх эрх мэдэл нь нагдургаат: эрүү, иргэний хэрэг тедийгүй эрх зүйн бусад "бүх" маргааны эцслийн хянан шийдвэрлэх; хөөрдүгаарт: хууль тогтоо, гүйцэтгэх эрх мэдлийн байгуулагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор гаднын хяналт тавьж хэрэгжүүлэх чиг үүргээ бүхий терийн эрх мэдлийн бие даасан салсаа мэн"¹⁶ гэж шүүх эрх мэдлийн мен чанарын тодорхойлсон байна.

Доктор (Sc) Н.Лүнэндорж
“Төрийн эрх мэдлийг хуваарилах амар хялбар ажил биш. Энэ хуваарилалт агууллын болон хэлбэрийн талтад. Хэлбэрийн хуваарилалт амархан, хамгийн хэцүү нь агууллын хуваарилалт. Хүмүүсийн, тэр дундаа төрийн албан хаагчдын итгэл, үнэмшил, албанаас сойл, үзж ажиллагаанд хуваарилах нь цад хугахаар, хэгжсэний шаардсан хамгийн хэцүү асуудал”⁶ гэж.

Үүнтэй адил шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангах үйл явц мөн хоёр талтай. Үндсэн хуулиар шүүх эрх

мэдлийн бие даасан эрх мэдэл гэдгийг бататгасан боловч хэрэг дээрээ түүнийг бие даасан эрх мэдэл болгоход цаг хугацаа шаардлагатайг бодит амьдрал харуулж байна.

Тэрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг Монголын төр шинэ Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрч, тус хуулийн 47 дугаар зүйлийн 1-д «Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагчих юү шүүх хэрэгжүүлнэ» гэсан Үндсэн зарчмын бий болсон юм.

Үндсэн хуулийн энэ заалтад нэгдүгээрт: шүүг бол бусад эрх мэдээс хараат бус, бие даасан эрх мэдэл; хөөрдүгаарт: шүүх эрх мэдлийн чиг үргүүний халдагшгийн байрлыг Үндсэн хуулийн төвшинд тогтоож өгснөөс гадна урьд нь шүүхийн хяналтад байгаагүй харэг маргааныг шийдвэр Үндсэн хуулийн эрхийн нээж илгээн юм. Ингэснээр шүүхийн цоо шинж институт - Үндсэн хуулийн Цэц бий болж, Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу хянан хэлэлцэл, маргааныг шийдвэр, зөрчил бүхий шийдвэр, үйл ажиллагааг хүчингийн болгох, зөрчилчийн эрхийг сэргээж, эрхийг гүйцэтгэх болсон юм.

Түүнчлэн Монгол Улсын шинэ Үндэснээ хууль шүүх эрх мэддэйг шүүхээс өөр ямар ч субъект эрхэлж ёсгүй, шүүх хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс бурзан тусгаар, ямар ч нэхцэлдэх хуулиас гадаар шүүх байгуулах, шүүх эрх мэддлийг өөр байгууллага эрхэлж хэрэгжүүлэхийг хориглох, шүүхийг зөвхөн Үндэснэ болон бусад хуулийн дагуу байгуулах мэн тогтоох, гүйцэтгэх эрх мэддлийн байгууллагын албан тушаалтны нэрээр “Ерөнхийлгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, тэр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ургзж хэрэгжүүлэхэд хендлэнгээс оролцож болохгүй” гэж нарийвчлан заасан нь шүүхийн үйл ажиллагаанд бусад эрх мэдлээс оролцож чиглэл агахгүй.

нэлээн дех шүүхийн түүхийг шинэ Үндсэн хууль эрх зүйн хувьд хязгаарлаж, шүүх бие даасан, шүүгч хараат бус байх баталгааг Үндсэн хуулиар хуульчилсан юм.

Монгол Улсын Дээд шүүх
Үндэсний хуулийн бусад хуулийг зөв
хэрхаглах талаар албан ёсны
тайлбар гарагж байхаар заасан нь
хууль тогтоо эрх мэдлийн хууль
тайлбарлах замаар хянах, наг
талаас хуулийг нэг мөр ойлгож,
хэрэглэх, тодруулаж агуулгатайгаас
гадна хууль тогтоо эрх мэдлийн
хууль тогтоо ажиллагданы явцад
гарсан алдаа зөрчилж засаж, хянах
байгаа хувьтой.

Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2-д “Улсын Дээд шүүхийн шийдвэр”, түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал билүүлжээ. “Хэрэв Улсын Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилавл түүнийг Улсын Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэж тус тус заасан Нийшүүхийн шийдвэрийг шүүхээс өөр ямар ч субъект вөрчлөхгүй, шүүхийн шийдвэрийг төрийн бүх байгууллага, албан тушаалттан заавал билүүлжэхийг хульчилж, шүүх өөрийн чиг үүргээ үйл ажиллагааны шат бүрд хэрэгжүүлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 2-т “Шүүхийн зохион байгуулалт уйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан нь шүүх, шүүгч гагцүү хуульд захиргадаа зарчмаас гадна шүүхийн бие даасан байдлын хамгаалсан, шүүхийн бүтэц, зохион байгуулалт, уйл ажиллагаанд хуулийн бус аргаар өвчлелт оруулах, нөхөнөх зэрэг аливaa явдлын хязгаарласан заалт орсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-д "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын хангах зорилгоор Шүүхийн Ерөнхий Зөвлөлт ажиллана гэжээ. Энэхүү байгууллага нь шүүн таслах ажиллагаанд

оролцохгүйгээр хүний неец, төсөв санхүү зэрэг шүүхийн байгууллагын бие даан, тогтвортой, хаарахаас ажиллах нэхцэлийг хангаж ажиллахаар хуульчилсан нь шүүх эрх мэдлийн бие даасан байдлын зохион байгуулалтын нэг юм.

“Шүүх улсын төсөв

санхүүжин. Шүүх уйл ажиллагаагаа явууллас эдийн засгийн баталгаагаар хөтөнчийн "Эр хангана" гэх Үндэсн хуулийн 48 дугаар зүйлийн 3-д заасан нь шүүх бие даасан, шүүх эрх мэдэл эдийн засгийн хувьд хараат бус байх Үндэсн хуулийн эрх зүйл баталгаас болсон юм. Хуульын Ц.Нямдорж Шүүх бие даасан улаан шүүх эрх мэдэл эдийн засгийн хувьд хараат бус байх тухай Үндэсн хуулийн энэ заалт "шүүхийн ажлын нөхцөл, шуун таслаах ажиллагааны зардал, шүүгчийн цалин хангамж зэрэг нэг нэгээс харилцан хамааралтай олон сандар асуудлыг багасган ойлголт бөгөөд ал нь дутуу дулимас, хуралцлагүү мутуй бол шүүх хараат бус ажиллаж чадахгүй хэмзэн шүүхийн эдийн засгийн баталгаагаар иж бүрэн авч узж эйстőй" гэж хэлсэн билэг

Доктор, профессор Б.Чимиджийн үзүүлэлтээр эхийн 1-д "Шүүгч хараат бус байж гагчхуу хуульд захирагдана", 64 дүгээр зүйлийн 2-т "Үндэсний хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхээс гагчхуу Үндэсний хуульд захирагдах бөгөөд албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна" гэж заасан нь шууzy эрх мэдлийн мэн чанар, гол онцлог, шударга ёс, шүүгчийн статусын амьтад сүнсийг илэрхийлсэн Үндэсний хуулийн зарчмын бөгөөд шинэ узлал баримтлалын цөм нь мөн² гэсэн байна.

Эдгээрээс дүгнэн үзвэл
Монгол Улсын шинэ Үндсэн хууль,
шүүх шүүгчийн шүүн таслах ажлаас
шүүх эрх мэдэлд шилжүүлэхэд
тухэн алхам болжаа.

Шүүх эрх мэдэл бэхжих тогтох эсэх нь шүүхийн шинэтгэлээс хамаарах эзгээтгэй цаг мөчид оршиж байна.

¹ Ц.Нямдорж Шүүхийн хараат бус байдлын эдийн засаг зохион байгуулалтын баталгааг "Шүүх эрх мэдэл-Шинэ зуун" олон улсын онол практикийн бага хурал. УБ. 2001 он. №12 даг. тал.

У., 2001 ог. 50 дахь тал.

Б.Чимидж Шүүх эрх мэдлэйн талаархи Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухайд –Шүүх эрх мэдэл –Шинэ зуун” олон улсын онол практикийн бага хурал. УБ., 2001 ог. 50 дахь тал.



Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотолгооны онол, практикийн асуудал

Улсын дээд шүүхийн шүүгч Д.Пунцаг

Нэг. Захиргааны хэргийн шүүхийн нотолгооны тухай ойлголт

Нотолгоо бол хүний едөр тутам хэрэглэдэг танин мэдэхүйн үйл ажиллагааны нэг төрөл боловч практикт танин мэдэхүйн үйл явц нь яйдаа урган гарч, тодорхой зорилго агуулсан байдал. Тэгвэл шүүхийн нотолгоо нь бодит үнэнний тогтоо, албанаас маргааны эцэслэн шийдвэрлэх зорилготой танин мэдэхүйн үйл ажиллагаа юм.

Захиргааны байгууллага, албан тушаалтнаас нийтийн эрх зүйн хүрээнд гаргасан, захирамжилсан шинжтэй актын ур дагавар нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчилт гэж үзсэн иргэн, хуулийн этгээд уг эрээс хамгаалуллахаар Захиргааны хэргийн шүүхэд нохиэмжлэл, хүснэгт, гомдол гаргах эрхтэй бөгөөд уг нэхэмжлэл, хүснэгт, гомдол үндэслэлтэй эсэхийг хэргийн орлогчид болон шүүх нотлог ууртгатай. Өөрөөр хөлбөл, тухайн актын хууль зүйн үндэслэлийг шүүхээр хянуулна гэсэн уг. Захиргааны актын хууль зүйн үндэслэлд: 1.Захиргааны акт гаргах болсон нөхцөл, шалтгаан; 2. Актын гаргахдаа хуулийн зүйл, заалтыг хэрхэн зөв хэрэглэсэн эсэх; 3. Акт гарсны улмаас үүссэн үр дагавар; 4. Актын боловсруулах, ёсчлох, хүргүүлэх шаардлагын тус тус хамаараад бөгөөд үүний шүүх нотлог баримтын үндэслэлийг тогтоох уург хүлээн. Нотолгооны энз зарчим бол захирамжилсан хэрг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог бөгөөд онол, арга зүйн хувьд судллагдах шаардлагатай садрэв мен.

Захиргааны хэргийг хуульд нийцүүлэн, зөв шийдвэрлэх үндсэн нөхцөл нь шүүх тухайн хэргийн нотлогдвол зохих байдлыг зөв тодорхойлж, нотолгооны хэргээл болон хэргээг хамааралтай, ач холбогддотой. Хуулиар зөвшөөрөгдсөн¹ хуульд заасан арга журмаар олж авсан нотлог баримтуудыг бүрэн цуглувуж, түүнд хууль зүйн үндэслэлтэй дүгнүүлж хийх явдал юм.

Захиргааны хэргэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт гаргах шүүхийн албана шийдвэрдэг гагцхүү нотлог баримтд тулгуурладаг тул шүүхийн нотолгоо нь хэргэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилтыг хангах хэргүүр болоод зогсохгүй, эрх зүйн харилцанд орлогчдын хооронд үүссэн маргааны хянан шийдвэрлэх үндсэн арга нь болдог бийээ.

Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тогтоох зорилгоор нотлох баримтыг цүглүүлж, шинжлэн

судалж, үнэлж байгаа шүүхийн болон хэргийн орлогчдын

хамтны үйл ажиллагаагаа

захиргааны хэргийн шүүхийн

нотолгоо гэж тодорхойлж болно.

Шүүхийн нотолгоо нь нотолгооны зүйл, нотолгооны хэргэсэл, нотлох баримт гэсэн ойлголтуудас бурдаж бөгөөд эдгээр нь шинжлэх ухааны бие дасан ухагдахуун боловч бие биенээ тодорхойлдог өөр хоорондоо харилцан хамааралтай танин мэдэхүйн шинжтэй бодит үйл ажиллагаагаар дамжин хэргждэг үйл явц юм.

1. Нотолгооны зүйл

Эрх зүйн тулгуур баримтуудад нотолгооны зүйлийг "нотлогдвол зохих зүйл" гэж үзсэн байдал².

Иргэний хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын үндэслэлийг тодорхойлж байгаа нөхцөл байдал буюу зохигчдын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл, үүргээ үүссэн гэм хор, өв залгамжлах эзэр нөхцөл тэгш эрхийн үндсэн дээр хэргэжих байдал нь нотолгооны зүйл буюу нотлогдвол зохих зүйл болдог.

Тэгвэл захиригааны хэргийн нотолгооны зүйл буюу нотлогдвол зохих зүйл нь зөвхөн нэхэмжлэлийн шаардлагад хамаарах маргаан бүхий захиригааны акттай³ холбоотой үйл баримт байна. Захиргааны хэргийн шүүхийн үндсэн ажил бол захиригааны актын хууль зүйн үндэслэлийг хянаад чиглэдэг болохкоор нэг төрийн нотолгооны зүйлийг ажилладгад гэж үзэж болохкоор байна.

Захиргааны акт нь тушаал, захирамж, албан шаардлага, дүгнэлт, шийдвэр, дүрэм, заавар, үйлдэл, эс үйлдэхүүгээс мэт олон хэлбэртэй байх бөгөөд үр дагавараас хамааруулсан нотолгооны зүйл нь өөр, өөр агуулгатай байна. Тухайлбал, захиригааны актгыг хүчинчгүй болгуулах, илт хүчин төгөлдөр болохыг хүзэн зөвшөөрүүлж, актгыг өөрчлүүлж, төбөрөйг багасгуулах гэх мэт.

Захиргааны хэргийн нотолгооны зүйл болох үйл баримт гэдэгт:

¹ Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 33 дугаар тогтолцоог.

² Д.Баярсайхан "Эрх зүйн онол". УБ., 2000 он.

³"Захиргааны акт" гэж нийтийн эрх зүйн хүрээнд тодорхой нэг тохиолдлыг зохицууллахаар захиригааны байгууллага, албан тушаалтнаас амарж буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шүүд бий болгодог нэг удагийн захирамжилсан үйл ажиллагаа; Энэ хуулиар захиригааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /тогтоол, дүрэм, заавар, журам-/ыг захиригааны актад хамааруулна.

1. Нэхэмжлэл дурдагдсан шаардлагын үндэслэл болж байгаа ўйл баримт;

2. Хариуцгачийн татгалзлын үндэслэл болж байгаа ўйл баримт;

3. Сөргөт нэхэмжлэлийн үндэслэл болж байгаа ўйл баримт;

4. Бие даасан шаардлага гаргах байгаа гуравдагч этгээдийн шаардлагын үндэслэл болж байгаа ўйл баримт зэрэг багтана.

Дээрхээс гадна нийтэд илрэхий болсон баримт, шүүхийн хүчин төглөрд шийдвэрээр нэгэнт тогтоогдоон ўйл баримт зэргийг хамааруулж болно.

Нотолгооны зүйлээ зөв оновчтой тодорхойлохын тулд юуны өмнө нэхэмжлэгч, хариуцгач, гуравдагч этгээдийн санна заригто, нэхэмжлэлийн шаардлага, татгалзлын утга агууллыг сайтар судлахын зэрэгцээ тэдээргэйр харьцуулж үзэх зэрэгтэй. Нотлогдвол зохиц зүйлээ зөв тоогоо нь харж ач холбогдолтой нотолгооны хэрэгслийн олх, цуглуулажаа дехэмтэй болохын дээр хэрэглэгдэвэл зохих хуулияа тодорхойлох, хэргийг шүүхийр, үнэн зөв шийдвэрээрх үрдүүчилсан нехцэл ни болно.

2. Нотолгооны хэрэгслэл

Нотолгооны хэрэгслэг гэсэн ойлголт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгагдаагүй, онолын шинжлэх ойлголтын. Нотолгооны хэрэгслэл нь өөрөө шуд нотлох баримт болдоггүй бөгөөд танин мэдхүйн Үйл явцын үр дундаж баримт мэдээлэл буюу нотлох баримт болдог. Хэрэгт цугларсан ўйл баримт бүхэлдээ нотолгооны хэрэгслэл болно.

Хэргийн оролцогчид /нэхэмжлэгч, хариуцгач, гуравдагч этгээд-/ын нэхэмжлэл, тайлбар, гомдол, хүснэг болон түүнд хавсаргах ирүүлсан бичмэл баримт, нотолгоо болгосон кино ба гарал зураг, зураглан, дүрс, дууны бичлэг, бусад зүйлс, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх санаачигтараа эсхүл хэргийн оролцогчдын хүснэгтээр олж цуглупсан бичмэл болон зд мөрийн баримт, гэрийн мэдүүлэг, төвлөөлгөч нар гэрчэрээ асуулгах

туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэргийг захиргааны хэргийн нотолгооны хэрэгслэл болж байгаа ўйл баримт;

5. Сөргөт нэхэмжлэлийн үндэслэл болж байгаа ўйл баримт;

6. Бие даасан шаардлага гаргах байгаа гуравдагч этгээдийн шаардлагын үндэслэл болж байгаа ўйл баримт зэрэг багтана.

Дээрхээс гадна нийтэд илрэхий болсон баримт, шүүхийн хүчин төглөрд шийдвэрээр нэгэнт тогтоогдоон ўйл баримт зэргийг хамааруулж болно.

Нотолгооны зүйлээ зөв оновчтой тодорхойлохын тулд юуны өмнө нэхэмжлэгч, хариуцгач, гуравдагч этгээдийн санна заригто, нэхэмжлэлийн шаардлага, татгалзлын утга агууллыг сайтар судлахын зэрэгцээ тэдээргэйр харьцуулж үзэх зэрэгтэй. Нотлогдвол зохиц зүйлээ зөв тоогоо нь харж ач холбогдолтой нотолгооны хэрэгслийн олх, цуглуулажаа дехэмтэй болохын дээр хэрэглэгдэвэл зохих хуулияа тодорхойлох, хэргийг шүүхийр, үнэн зөв шийдвэрээрх үрдүүчилсан нехцэл ни болно.

7. Нотолгооны хэрэгслэл

Хэргийн оролцогчдын тайлбар. Шүүхийн нотолгооны онолд оролцогчдын тайлбарыг нотолгооны хэрэгслэл гэж үзэдэг. Хэргийн оролцогчдын хүсэл, зорилгоос хамаарч нэхэмжлэл, тайлбар нь өөр, өөрийн ашиг сонирхлыг илрэхийлсэн, хамгаалсан агуулгатай, нотлох баримт болохуүц шинж багатай байдал тут тайлбарыг бусад нотолгооны хэрэгслийн давхар батлах шаардлагатай. Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар хариуцагчын нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн буюу түүний зарим хэсгийг хүлээн зөвхөөрсэн, мөн хуулийн 43 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэн хэлэлцээн бол бусад нотолгооны хэрэгслийн давхар батлах шаардлагатай. Шүүх хэргийн оролцогчдын тайлбарыг албанад гаргуулж болохгүй бөгөөд хуулиар тогтоосон арга журмаар гаргасан тайлбар нь нотолгооны хэрэгслэл тооцогдоно.

8. Гэрчийн мэдүүлэг.

Хэргийн оролцогчид өөрийн тайлбарын нотолгоо болгож хүмүүсээс бичүүлж авсан "тодорхойлолт" нэртэй баримтуудыг шүүхэд ирүүлдэг. Энэ нь нотолгооны хэрэгслэл биш юм. Яагаад гэвэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дугаар зүйлийн агуулга нь хэргийн оролцогчид тэдээргэйн өмвөлөгч, төвлөөлгөч нар гэрчэрээ асуулгах

хүнээ звааж, хүснэгт гарган, шүүгчээр мэдүүлэг авахаарх эрхтэй байхаар тусгайлан зохицуулсан тул бусдын "тодорхойлолт" гэх баримт нь нотолгооны хэрэгслэл болж чадахгүй. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан үндэслэл, журмаар авсан гэрчийн мэдүүлэг нь нотолгооны хэрэгслэл болно. Гэрчийн мэдүүлэг авах ажиллагаа нь зөвхөн хэргийн оролцогчид хүснэгт шаардлагар эсхүл шүүхийн санаачилгаар хийгдэн.

9. Бичмэл баримт.

Захиргааны хэргийн шүүхэд хамгийн ач холбогдолтой тооцогдох нотолгооны хэрэгслэл бол бичмэл баримт юм. Захиргааны хэргийн шийдвэрээд алх болбогдож буйх фактыг агуулсан бүх төрлийн албан бичиг, зураг, тэмдэглэл, зураглал зэрэг нь бичмэл нотолгооны хэрэгслэл болно.

Захиргааны байгууллага, түүний албан тушаалтын шийдвэр, ирэгд, хуулийн этгээдээс захиргааны байгууллагатай харьцааж байсан хүсэл, өргөдөл зэрэг бичгийн хэлбэрээр хүсэл зоригоо илрэхийлсэн баримтууд нь захиргааны хэрэг шүсгэх, хэргийн шийдвэрлэх ажиллагаа явуулж үндэслэл болдог онцлогтой "нотолгооны" хэрэгслэл юм. Үүнээс үзвэл нотолгооны зүйл буюу захиргааны акт маань өөрөө бичмэл хэлбэртэй байдгийн хувьд нотолгооны хэрэгслэл болох төдийгүй шүүд нотлох баримт ч болдог байна.

Хуулийн фактуудыг угийгэсэн эсхүл байгаа гэдгийг тодорхойлоон тэмдэглэлийн давтэр, захидал, гэрчилгээ, үзүүлэл, лавлагча, зураг, зураглал зэрэг нь гэрчилэх тодорхойлоон шинжлэйн албан бус, хэлбэрийн хувьд энгийн нотолгооны хэрэгслэлд хамаарах бөгөөд бусад нотолгооны хэрэгслийн давхар баталгаажсан байх шаардлагатай.

Бичмэл нотлох баримтыг эхээр нь, хэрэг эхийг нь егөх боломжгүй бол нотариатчаар гарчилгээсэн хуулиарыг гаргаж егөх үргийг бүх тал хүрээнд. Нотолгооны энэ шаардлагыг үл ойшоож, ялангуяа, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн алба, Нийслэл, дүүргийн

газрын албанаас "хуулбар үнэн", "...баримтавс хуулбарлав" гэсэн тэмдэг, тэмдэгэлтэй баримт ирүүлдэг, түүний нь шүүх хүлээн авч нотлох баримтын хэмжээнд үнэлдэг явдал оршиор байна. Ийм хууль бус ага, журмаар гаргасан бичмэл баримтыг хүлээн авсан, үнэлсэн нь хэргийн бусад оролцогчдод эргээзж төрүүлж, шүүхэд ул итгэх байдлыг бий болгох, негев талаар шүүхийн шийдвэр хууль ёсны болох чадахүй хүчингүй болох үндэслэл болж байна.

Тухайн факт ўйл баримт/-ыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүртгэж, баталгаажуулж байхар хуульд заасан бол тэдээрээс олгосон гэрчилгээ, лиценз, лавлагага нь нотолгооны хэрэгслэл болох бөгөөд түүний олгох ўйл ажиллагаа нь хуулийн хураанд байгаа эсэхийт нотлох үүргийг хэргийн оролцогчид, шүүх хүлээн.

* Эд мөрийн баримт. Шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа захирагааны хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг дагуулж байгаа эд зүйлсийг эд мөрийн баримтад тухайн маргаанд шүүд ба шүүд бус ач холбогдолтой бүх терийн дээд зүйл, зарим тохиондол бичмэл баримт хамрагдана. Эд мөрийн баримтад тавигдах гол шаардлагтаа бол гагцхүү хуульд заасан ага, журмаар олж авсан байхын дээр анхны байдлаараа бэхжсэн байж явдал юм. Үүнд шүүх голлон анхаарч эд мөрийн баримтыг хүлээн авах, хадгалах, шилжүүлж, буваах, устах ажиллагаат зөв шийдвэрлэх хэрэгтэй.

* Шинжээчийн дүгнэлт. Захирагааны хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагааны явад шинжилж ухан, техники, няяглан бодох бүртгэл, газар, геологи зэрэг тусгай мэдлэгийн үнэлэлт зайлшгүй шаардлагадаа асуудлаар шинжээч томилж, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулдаг. Шинжээч томилж, дүгнэлт гаргуулах асуудлыг Захирагааны хэрэгт хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар оролцогчдын хүснэгтээр эсхүү шүүхийн яврын шүүхийн санаачилгаараа хэргийг шүүх хуралдаанд болтгэх ажиллагааны үед шүүхийн захирамж, шүүх хуралдаанаар хэлэлцэх үед

шүүхийн тогтоол гарган, мэргэжлийн байгууллагыг эсхүү тухайн асуудлаар мэргэшсэн тодорхой хүний шинжээчээр томилж шийдвэрлэнэ. Шүүх, шинжээчийн урьд гаргасан дүгнэлтийн тодорхой бус асуудлыг тодруулахаар шинжээчийг дахин томилж нэмэлт шинжилгээ хийлгэж болно.

Маргаантай асуудлын талаар сонирхогч этгээд захирагааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахаас эмне улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж, дүгнэлт гаргуулж байна. Энэ нь шинжээчийн дүгнэлт биш бөгөөд ихэвчлэн хэн ямар зорилгоор хандансаа хамаар мэргэжлийн хяналтын байцааг нар тухайн этгээдийн хүсэл, сонирхолд нийцэн дүгнэлт гаргасан явдал түгээмэл ажилгагддаг. Ийм замаар гаргасан дүгнэлтиуд нотолгооны хэрэгслэл болох боловч шайлигийг дахин няяглах, хэргийн бусад нотолгоог харьцуулж шаардлагатай.

* Шүүхийн даалгавар. Захирагааны хэргийн шүүхэд хэлэлцэгдэх хэргийн талаар өөр орон нутаг болон гадаад улсаас нотпох баримт гаргуулах шаардлагатай гэж шүүх үзвэл Захирагааны хэрг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т зааснаар тодорхой ажиллагаа гүйцэтгэж ирүүлхийг харьялах шүүхэд даалгана. Шүүхийн даалгавар биелүүлсөн тэмдэглэл, ирүүлсэн материал нь нотолгооны хэрэгсэл болно.

Шүүхийн даалгаварт ямар хэрэгт даалгавар гүйцэтгүүж барьгаагаа тусгахын зэрэгцээгээр ямар баримтыг ханаас гаргуулах, юунд үзлэх хийг, гарчийг хэрхэн юуны учир асуух, даалгавраг гүйцэтгэж ирүүлэх хугацаа зэргийг дурдах холбогдох нэхэмжлэл, хариуцагчны тайлбар, бусад материалыг хуулбарлан хүргүүлээ. Даалгавар гүйцэтгэх шүүхэд хэргийн талаар тодорхой мэдээлэлтэй гөхгүй, шүүхийн захирамж явуулдагаас нотолгооны шаардлагтаа хангахгүй "чангаргүй" баримт иргэдэг анхаарах хэрэгтэй. Даалгаврыг хүлээн авсан шүүх захирамжид дурдсан ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх,

тогтоосон хугацаанд хүргүүлэх үрэгтэй.

Шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх ажиллагааг гадаад улсын шүүхэд хандан хэрэгжүүлэхдээс эрх зүйн талаар харилцаа туслалицаа үзүүлэх гарээ болон бусад гарээ байгуулсан улс орнуудтай Монгол Улсын дээд шүүхээр эсхүү тухайн зүй, дотоод хэргийн яамаар дамжуулан явуулна. Гэхдээ гадаад улсын шүүхээр даалгавар гүйцэтгүүлэх нь цаг хугацаа ихээхэн зарцуулагдах, наидвэр багатай ўйл ажиллагаа тул аль болох бусад нотолгооны хэрэгслээр бодит байдлыг тогтоохыг эрмэлзэх нь зүйтэй.

* Тэмдэглэл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмыг шүүх, шүүгч, хэргийн оролцогчид сахин биелүүлэх үргэлжтэй. Энэ үргээ хэрхэн ёсчлон биелүүлснийг нь харах "толь" бол тэмдэглэл юм. Шүүхийн ажиллагааны бүхий л ўйц, шийдвэрийн агуулыг бүрэн тусгаж баримтжуулсан нотолгооны хэрэгсэл /Бичмэл баримтыг/-ийг тэмдэглэл гэнэ. Тэмдэглэл хоёр төрөлтэй байна. Нэгдүгээрт; Үйлдлийн тэмдэглэл. Хоёргуудаар; Шүүх хуралдааны тэмдэглэл.

Үйлдлийн тэмдэглэл гэж хэргийн оролцогчтой шүүх, шүүгч, шүүхийн ажилтнаас харилцсан байдал болон нотлох баримтыг гаргах, хүлээн авах, олж цугуулнах, бэхжүүлэх, шинжилгэн судлах, хадгалах, шилжүүлж, устах зэрэг ажиллагааг баримтжуулсныг тусгасан бичмэл баримтыг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй бүх шатны шүүхийн хуралдааны үед болсон ўйлдэл, ўйл ажиллагаа, оролцогчдын эхийг хангасан байдал, мэтэлдээний явц, нотлох баримтыг шинжилгэн судласан тухай болон шүүхийн шийдвэрийн агуулга зэргийг бүрэн тусгасан бичмэл баримтыг хэлнэ.

Үйлдлийн тэмдэглэл нь шүүгчийн санаачилгаар эсхүү оролцогчдын хүснэгтээр шүүх хуралдааныаас бусад аль ч үе шатанд хөтөлгөж болно.

Хэргийн оролцогч давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцогчий бол

* Д.Пүнцаг

шүүх хуралдааны тэмдэглэл үйлдвэрхүй байж болдог. Харин захирагчинаа хэрэг хянан шийдвэрэх тухай хуульд заснаар давж заалдах шатны шүүх анхан шүүхэд хэвлэлтэдээгүй нотлог баримтын шинжилгүүн судлах, үнэлэх эрхтэй тул шаардлагатай гэж үзэл хэргийн оролцож хуралдаанд оролцогүй ч гэсэн нотлог баримтын хэрхэн хэвлэлцээнээс оролцогчдод ойлгомжтой болгохын тулд тэмдэглэл үүндэж тээдэнд таницуулж болно.

• Нотолгооны бусад хэрэгслэ. Эрэ зүйл маргааны хүндэлслэтийн шийдвэрээр хүнзээс хүний танин мэдэж болох янз бүрийн аргааслаалж болно. Үүний нэг хэсэг нь нотолгооны бусад хэрэгслэй буюу шүүхээс явуулах узлаг, туршилт, танжыг олжуулж ашиглалаа бөгөөд түүнийг баталгаажуулсан тэмдэглэл юм. Аливаас үйлдэл, тэмдэглэл нь дамгаараагаа нотолгооны хэрэгслэдээ болж чадахгүй. Тухайн хэрэгт ач холбогдолтой нөхцөл, байдлыг нотлох, бэхжүүлэх зорилготой үйлдэл, түүний бичигийн хайлбарзрэлтийн эхийн тэмдэглэлтэйгээ нийлиж нотолгооны хэрэгслэдээ болгод.

Хөргийн нөхцөл байдлыг
туорууллахад чиглэсэн
хойшлуулшгүй ажиллагааг
марглагдах талуудын хүснэгтээр
эсхүүл ёөрний узмээж газар
дээр нь туршилт, узлэл хийж
магадаг шаардлагад гардаг.
Ялангуяа, шүхэд ирүүлэх
боловжгүй зарим зүйлийг газар
дээр нь узж, баримт бичигийг эхтэй
нэхарцуулан тулагх дотортуулж,
ямар нэгэн объектийн байршилыг
дорхдорхийн зэрэг зорилгоог
хисэн узлж, бодит байдлыг тогтоох
туршилт, танхж оптуулж ажиллагааг
шүүхүү веөвөө явуулж үйлдсэн
тэмдэглэл нь маргааныг хянан
шийдвэрлэхэд ихэзжэн ач
холбогдуулж нотогоонхи хэрэгслэл
болж. Негеё талаар шүүхийн узлаг,
туршилт нь шүүгчийн нотох
баримтыг эргэлзээгүйрэв үзлэх
итгэлийг бил болгогд зөрэг үр
сагасатай

Манай шүүхүүдэд ажиглалдсан нэг дутагдал бол шүүхийн үзлэгийг "хэргийн газрын үзлэг" болгож шуугчийн туслах эскул нарийн бичгийн дарга нар хийдэг

явлал юм. Тэдний хийсэн үзлэг нь нотлох баримт байтугай нотолгооны хэрэгслэл ч болж чадахгүй дээр хуулд заасан арга журмаар авагдаагүй, нотлох чадваргүй "цаас" гэж үзэхээсөө аргагч.

Шүүгчийгээр, шүүх бүрэлдэхүүнгүйгээр шүүх гэсэн ойлголт бий болгохгүй. Энэ үднээс авч үзвэл шүүгч, шүүх бүрэлдэхүүн эзлэгчийг удирдан явсан уулж, шүүгчний туслах, нарийн бичигийн дарга үйл ажиллагааны нь тэмдэглэлийг үйлдсэн нөхцөлд жинхэнэ шүүхийн эзлэ болох төдийгүй захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болж чадна.

Нэгээ талаар нүүрэлдүүлэн байцаах ажиллагаа түүний тэмдэглэл захираганы хэргийн нотолгооны бусад хэрэгслэд хамааруулж болно гэж узж байна. Захираганы хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нүүрэлдүүлэн байцаах асуудал тусгагдаагүй хэдий ч нотолгооны зүйлийг зөв тодорхойлоо, хэргийн шалгах арга сонгох, нотолгооны хэрэгслийдийн харьцуулам узэх, ямар баримтарт ямар шаардлагат, татгалзалаа нотолж, угүйсгэж байгааг нь тодруулахад энэ аргыг хэрэглэх нь алх болгодогийт юм.

Хоёр. Нотлох баримт

Захиргааны хэргэй хянан шийдвэрлэх тухай хуулийн 30, 31 дүгээр узьд "нотогооны хэрэгслэг" гэсэн ухагдахуун тусгагдаагүй, зөвхөн нотлох баримт гэсэн нэр томъёог хэрэглэсэн. Тэгээрээ энэ содват нотлох баримтад тавигдаж шаардлагыг хангасан, шүүх, шүүчгүүнэлхээ боломжтой нотлох баримтгэг гаргах, илрүүлах буюу заах, олгахаа, цуглуулахаа судалж шалгах, унэлгээ гэсэн ойлголтуудыг хамардагчид шийдвэртэй чадаа

хамааруулж нь зүйлтэй эзжүүн.
Нотогооны хэрэгслийг ашиглан шүүхийн нотлох баримтыг тогтоодог тул нотлох баримт, нотогооны хэрэгсэл гэдэг ойлголтуудыг нэгэн зүйл мэтээр ойлгож болгохгүй. Иймээс юуны өмнө тэдгээрийн харилцан хамаарын авч узх нь хувал.

Хэргийн оролцогчдоос ирүүлсэн болон шүүхийн шаардаж гаргуулсан баримт материал нь нотлох баримт, нотолгооны хэрэгслийн "цуглуулга" юм. Ер нь нотлох баримтын шинжилгээний

ундэслэлгүй зөвхөн хэлбэршүүлсан талаас нь хандаж өөрсөт дүгнэхийн болгохыг. Магадгүй хуульд заасан журам, шаардлагыг хангасан /Нотатор/гаар үндэслэлэн гээ мэти/ (боловсруулж бус арга замаар /Тулган шаардах, запилан мэхлэх гэх мэти/ опти авсан, бодит биш /Хуурамч гэх мэти/ баримт шүхийн шийдвэрийн үндэслэл болсон байх явдал гардад. /Цүргүүлэг/ дотор маань хуулиар зөвхөөрдөгдэгүй, тухайн хэрэгт хамаараалгүй баримт байж л байдал. Эдгээрийг нотлох баримтыг шинжлэн судлах, үнэлж явцад нотлох баримтаас хасах, гаргаж өгсөн этгээдэд нь эргүүлж итгэх замаар шийдвэрлж, шүүх гагчихууд нотлох баримтын шаардлагыг хангасан баримттай улэж, түүнийээс унэлж учиртай. Энд нь нотлох баримт, нотоголгохи хэрэгслэл гэдэг ойголтуудын зааг яягдаа, харилцан хамаараал нь харалдаг болно.

Хэргийн оролцог нотлох баримт гаргахдаа, эсхүл хүсэлт гарган шүүхээр нотлох баримт бурдүүлэх тохиолдолд тухайн нотлох баримтаар ямар үйл явдал, нэхцэл байдлыг тогтоо гэж байгааг дурдах, тодруулж шаардлагатай.

Иргэний хэрг шүүхэд хянам шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хасгийн "Хэргийн нотлох баримт нь ... нотолгооны хэргэлслэгт тогтоогодно" гэсэн заалтын дээр хөбөйглэлтэй ялгаатай гэдгийг нотолсны дээр харилцан хамаарлыг нь хуульчилсан заалт юм.

Негээ талаар мэн зүйлийн
37.1 дэх хэсэгт "Хэргийн
оролцоогоос өөрийн шаардлагыга
батгалаас үндэслэл байгаа, шүүх
хэргийн хянан шийдвэрлэхдээ ач
холбогдол бүхий, хуульд заасан
арга хэрээгээр олж авсан болдит
хөнгөл байдлыг тогтооход
шаардлагатай аливаа баримтат
мэдээллийн нотлог баримтган" гэж
нотлог баримтад тавигдах
шаардлагыг үндсэнд нь
тодорхойлжээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтас үзэл иргэний хэргийн нотлох баримт гэсэн ойлголтоос захиргааны хэргийн нотлох баримтын талаарх ойлголт

яяцуу ойлголт гэж үзэж болохоор байгаа юм.

Захиргааны хэргийн нотлох баримтыг олох, цуглуулах бурдуулж ажиллагаанд хэргийн оролцогчдоос гарна шүүх өврийн санаачилгаар болон оропцогчдын хүснэгт, шаардлагараар оропцох үүрэг хүлээгдийн дээр захиргааны хэргийн давх заалдах шатны шүүхэд хоригийн оролцогчид анхан шатны шүүхэд хэлэлцэгдэгүй шинэ нотлох баримт гаргах егехэй эрх нээлттэй байганд онцлогтой тул өргөн ойлголт гэж үзэж байгаа юм. Тухайгааны хэргэй хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1-д "Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээг яхь болгодог буюй нотлох баримтыг цуглуулсан, унэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэн", 31.2-т "... шүүх хэргэй хянан шийдвэрлэхдээг яхь болгодог буюй нотлох баримтыг байгууллаага, албан тушаалтан, иргэнээс гаргаж өгөхийг шаардлаад эрхтэй" гэсэн тусгайлан сохицуулалт байна. Негеэ талаар давх заалдах шатны шүүхэд хэргийн оролцогчид анхан шатны шүүхэд хэлэлцэгдэгүй шинэ нотлох баримт гаргаж өгөх, үнэлүүлэх эрхийн талаар Захиргааны хэрг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.1.6, 85 дугаар зүйлийн 85.6-д заажээ. Дээрх заалтуудаар хульг тоогоог захиргааны хэргийн оролцогчид болон захиргааны хэргийн шүүхэд илүү боломж, давуу байдал олгосон байна.

Захиргааны хэрг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримт нь Тодорхой эрх бүхий субъект /Захиргааны байгууллага, албан тушаалтан гэх мэт-/ийн гаргасан зөвхөн маргаан бүхий захиргааны актын гаргах болсон шалтгаан, түүний мэн чанар, агуулга, үр дагаврыг тогтооход чиглэгддэгтэй явуулж хүрэндэхийдээж ажиллагааг гэж үзсэн болно. Захиргааны хэргийн шүүхийг "дагласан шүүх" гэж нарлэдэг нь чүнтий холбоотой.

Захиргааны хэрг хянан

шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг гаргах, ирүүлэх буюу заах, олж авах цуглуулах, судалж шалгах, үнэлэх гэсэн хариулцаа бие биенээс нэхцэлдүүлсэн, хоорондоо салшгүй үйл ажиллагаанууд зайлшгүй хийдэгт. Эрх зүйн шинжлэх ухааны эрдэмтэд, судлаачийг дээр ажиллагаануудыг нотлогооны үе шат¹ гэж нарладгэг бөгөөд цвэр нотлох баримт гэдэг ойлголтой холбон тайлбарладаг байна.

1. Нотлох баримтыг гаргах

Хэргийн оролцогчид тэдээрийн төлөвлөгөө, өмгөөлгөгчөөс өөрт байгаа эсхүн хуульд заасан үндэслэл журмаар олж авсан баримтыг хянан шаардлагтаа буюу татгалзлын үндэслэлээг баталгаажуулахаа зорилгоор анхан болон давх заалдах шатны шүүх хуралдаан эхэлжээс эмне шүүхэд гарган өгөх эрхтэй. Хэргийн оролцогчдоos нотлох баримтын чанартай баримтыг нэхэмжлээ, тайлбартай хамт ирүүлж байгаа бол нэхэмжлээ, тайлбарьрыг хүлээн авах журмаар, бусад үед гаргын өгч байгаа бол хөндөнгийн өрүү, бусад этгээдийн байгуулсан албан ёсны баримт үйлдээх журмаар шүүх хүлээн авах нь зүйтэй. "Гаргажгэсэн баримт хэрэгт байхий байна, шүүх алга болгоод" гэсэн гомдол байнга гарч байгаад шүүхүүд дүргүүлж хийж арга барилгаа вөрлихээ хэрэгтэй. Энэхүү эрх, үүргийн нэгдэл нь нотлох баримтыг гаргахаа ажиллагааны үндсэн арга тедийрүү хуульчлагдсан журам юм. Харин гарган өгсэн нотлогооны хэргэсэл нь тухайн хэргийн хамааралт, яхь болгодогт эсэх нь вер асуудал.

Иргэний хэрг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйл "Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхэлжийн эмне гаргаж өгнө", мөн хуулийн 161 дугаар зүйлийн 161.5-д "Давх заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр шийдвэрлэгүй" шинэ нотлох баримтыг заах эрхтүй" гэж нотлох баримтыг анхан шатны шүүх

хуралдаан эхэлжийн эмне зөвхөн хэргийн зохигчид гаргах үүрэгтэй байваар зважээ. Гэтэл Захиргааны хэргэй хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.6-д "Давх заалдах баримт бичгийг ... хэрэгт хавсарж болно", 85 дугаар зүйлийн 85.6-д "Давх заалдах хурмаар хэргэй хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх шинээр цуглуулсан, хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж дүгнэх, үндэслэл болгох эрхтэй" гэх захиргааны хэргийн оролцогчид нэлээд өргөн эрэл олгосон байна. Ийнхүү хэргийн оролцогчдоos давх заалдах шатны шүүхэд шинэ нотлох баримт гаргах эрх олгож байгаа нь шүүх нотлох баримтыг тал бүрээс нь бодитой шинжлэн судлах унзах болопцоог нэzmдгүүдүүсэн ач холбогдолтой юм.

Хуулийн дээр зважт нь давх заалдах шатны шүүхэд нэгэнт ирүүлсэн нотлох баримт болохуйц баримтыг шүүх хуралдаанаар хэлэлц, нотлох баримтын шаардлагыг хангаж байвал үнэл, хэрээс эргэлзээтийг байвал унэлж шаардлагыгийн дээр нотлох баримтаас хасаж болно гэсэн агуулгатай юм. Харин давх заалдах шатны шүүх нотлох баримтын өөрөө олох, цуглуулах, хэргийн оролцогчдын энэ талаарх шаардлагыг бинеүүлэх үүрэг хүзэхгүй.

2. Нотлох баримтыг ирүүлэх буюу заах

Захиргааны хэрг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид Захиргааны хэрг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон эрхийнхээ хурээнд тухайн маргаантай холбоотой нотлох баримт, түүний эх сурвалжийг ирүүлэх ажиллагаа явуулах, хаана, ямар нотлох баримт, мэдээлэл байгааг өргөдөл, гомдол, хүснэгт, тайлбартай зааж² шүүхээр гаргуулж эрхтэй.

Нотлох баримтыг ирүүлэх нь оролцогчны чадвар, чадамж, эрх зүйн боловсролтой холбоотой байдаг бол нотлох баримтыг заах

¹ Г.Б.Батзориг Гэмт хэргийн нотлоогооны ерөнхий онол. УБ., 2002 он.

Б.Гандгаа Монгол Улсын нотлоогооны эрх зүйн үндэснээс асуудал. УБ., 2001 он.

² Омогтвийн тухай хууль. 12 дугаар зүйл: 12.2.3. эрүү, иргэний хэргийн нотлох баримттай танилцаа, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өврийн дээрлээр хувилж хуульбардан авах; 12.2.4. нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардлагуу буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлын шалгуулалт, шинжээчийн дүргүүлж гаргуулалт санал хүснэгт тавих; 12.2.7. хууль зүйн туслацдаа үзүүлжээд шаардлагатай баримт бичгийг байгууллаага, эх ахуйн нэгжээс гаргылж авахаар хэрг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчид хүснэгт гаргах, баримт салтгийг бажижүүлэх зорилгоор дуу, дүрс бичгээгийн хэргэсэл ашиглалаа.

нь өөрөө олох боломжгүй нотолгоог шүүхийн журмаар олж авахад чиглэсэн үйлдэлт. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамгийн түгээмэл хийгдэг ажиллагаа бол оролцогчдын заасан нотлох баримтыг шүүх илрүүлж, байгаа гэрээр нь гаргуулах, олж авах, цуглуулж ажиллагаа юм.

Хэргийн оролцогч хүсэлт гарган шүүхээр нотлох баримт бүрдүүлэх тохиолдолд тухайн нотлох баримтын ямар нехцел байдлын тогтоох гэж байгааг дурдах, тодруулж ехег, хаана байгаа, хэрхэн олж болох талаар тодорхой мэдээллийг шүүхэд өгөх шаардлагатай. Энэ үндэслэлээс нь хамаарч заасан нотлох баримтыг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэн. Өөр хангалттай нотолгоо шүүхэд байгаа болон тухайн хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй баримт гаргуулахыг шаардан завалт эрж хайх, олох, гаргуулах ажиллагаа хийх шаардлагатай байж болно. Ийм тохиолдола үндэслэлээ зааж хүснэгтийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргах байвал зохиin.

3. Нотлох баримтыг бүрдүүлэх, цуглуулах

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн хариуцлагатай үе нь нотлох баримтын бурдийг хангах шат юм. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хульд зааснаар шүүхээр хянан хөлзүүлэгдэх, хэрэфт шууд холбоотой баримт солтгийт эрж олох, шаардан гаргуулах, бэхжүүлж талаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд болон бусад оролцогчдын төдийгүй шүүхийн явуулж байгаа улж ажиллагааг нотлох баримтыг цуглуулж ажиллагаа гэнэ.

Шүүх болон хэргийн оролцогчид идэвхитийн харилцан ажиллагааны үр дүнд хэргийг шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан байх ёстой. Ер нь шүүх нотлох баримтын бурдуйлж болох бүхий л аргы хэрэглэж байж бодит үнэндийг тогтоох боломжийг олж авдаг. Энэ үдиэсээ авч үзвэл нотлох баримтыг бурдуйлж, цуглуулж ажиллагаа нь шүүхэд ногдох хариуцлага мен. Нотлох баримтыг хэргийн оролцогчдоос хүлээн авна, бусадаас гаргуулаха, шаардана, даалгана, албадна, эрж

хайна, өөрөө газар дээр нь үзнэ, туршина, мэргэшсан байгууллага, хүмүүсээр дүгнэлт гаргуулаха, тэгээд хэрэгт цугларсан нотлох баримт үзүүний тогтооход хангалтгүй гэж үзвэл оролцогчид нэмэлт нотлох баримт гаргахыг санал болгох, шаардаа заргрэж бололцостой бүх арга хэмжээг авна.

Тухайн хэргийн болон маргалдаг талуудын хувь заян нотлох баримтын бурдлээс ихэзэн хамааралтай.

Хэрэг шийдвэрлэгдэхэд хангалттай нотлох баримт цугларсан эсэхийг тухайн хэрэг дээр ажилласаа байгаа шүүгч доодот итгэл, мэдэлгэ, түршлэг дээрээс тулгуурлан үнэлж цэгнэдэлт. Нотлох баримтын бурдэл хангагдаагүйгээс шүүх хураалдан хойшлех, шүүхийн шийдвэр үндэслэлтэй мутуй гарч бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих, дээд шатны шүүх хэргийн талаар бодитой дүгнэлт хийх боломжгүй болох, шийдвэр хүчингийн болох, өөрчлөгдхөх эзргэлт гардагаар бий болдог. Тухайлбал, давж заалдах, хяналтын шатны шүүхээр хангадсан захирагааны хэргийн шүүхийн шийдвэрийн 44.0 хувь нь нотлох баримтын бурдэл хангагдайг байнаас хүчингий болж, өөрчлөгднөн анхан шатны шүүхээр дахин шийдвэрлэжсан байна.

4. Нотлох баримтыг судлан шалгах

Тодорхой хэргийг нотолгооны аль нийгээгээрэл, эскуү хэд хэдэн хэргэслийн туслаамжтайгаар шийдвэрлэх болох нехцэл байдлыг бурдуйлж байгаа нотлох баримт болохуийг шинж нь тухайн хэрэгт хамааралтай баримт мэдээллийг олж авсан үндэслэл, арга, журам нь хууль ёсны эсэхийг тодорхойлох чанар гэж уздаг. Нотлох баримт болохуийг нотолгооны хэргээгэлт мөн үү, нотолгооны хэргээгэл нь хэрэгт хамааралтай, нотолгооны ач холбогдолтой эсэх, хуулиар зөвшөөрдгэсэн болон хуульд заасан арга журмаар олж авсан, хуульд зааснаар баталгаажсан эсэхийг шүүх хянан үзнэ. Түүнээс гадна хэрэгт цугларсан нотлох баримт хууль ёсны эсэх, хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэх, эргэлзэгүй, үнэн бодитой эсэхийг шүүгч шалгах ёстой. Ийм шүүх хураалдааны мэттэлцээний шатанд

хэрэгт авагдсан бүх нотолгооны хэрэгслийг нэг бүрчлэн судлан шалгах, үнэлгэдэх нотлох баримтад тооцох эсэх, нотлох чадвараа алдах, нотлох баримтаас хасагдаа эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үг. Үүнийг нотлох баримтыг үнэлжээтийг шүүд адилтган ойлгох нь учир дутагдалтай. Учир нь шүүхэд хэлэлцэгдээгүй буюу судлалдагаагүй, хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй, хуульд заасан арга журмаар олж авагчийг нотлох баримтыг үнэлж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгэр зүйлийн 31.4 дахь хэсгийн "Нотлох баримт гаргах, цугларсан талаар хуульд заасан жуурмыг зөрчих олж авсан нотлох чадвара алдах бөгөөд захирагааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй", 31.8-ийн "Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрдөөгүй баримтыг хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй", 31.8-ийн "Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрдөөгүй баримтыг хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй" гэсэн заалтууд нь нотлох баримт болж чадахгүй нотолгооны хэргэлгийг томъёолсын дээр нотлох баримтад хууль зүйн утгаар тавивдаг шаардлагыг тодорхойлжээ.

Шүүх хураалдаан бэлтгэх ажиллагааны явцад шүүгч, шүүх хураалдааны явцад шүүх бүрэлдэхүүн, иргэдлийн төвлөлөгч, хэргийн оролцогчид нотлох баримтын нотолгооны ач холбогдолгын батлах, угүйзгэх, нэмэлт тодотгол хийх зэрэг нотлох баримтуудыг судалж, шалгах ажиллагаанд хамтараа оролцно.

5. Нотлох баримтыг үнэлж

Нотлох баримтыг үнэлж нь шүүхийн нотолгооны хамгийн хариуцлагатай эсийн үе шат бөгөөд нотлох баримтыг судлан шалгах үйл ажиллагаатай шүүх холбоотойгоор хослон хэрэгждэг. Тухайн хэрэгт хамааралтай, нотолгооны ач холбогдолтой, хуульд заасан арга журмаар олж авсан нотлох баримтыг шүүгч эрх зүйн ухамсыг удирдлага болон дотоод итгэлзээрээ үзнээ.

"Шүүхэд цугларсан нотлох баримтын нотолгооны шинж, зориулалтыг нь шүүх, хууль зүйн

талаас нь үнэлзлт, дүгнэлт хийх оюун санааны бүтээлж хандлагыг нотлох баримтыг үнэлэх гээн¹ гэж зарим эрдэмтэн, судлаач тодорхойлсонтой санал нь байна. Энд “шүүгчийн дотоод итгэл” гэдгийг “оюун санааны бүтээлж хандлага” гэж томъёолсон нь иөнөвчтэй болжээ.

Хуульд зассан үндэслэл журмаар цугларсан нотлох баримтууд нь шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын үндэслэлийн ямар нэг байдлаар батлах, эсхүл яцааж үгүйсэж шудчилгэлсэн шинкүйт байдал.

Нотлох баримтыг үнэлэх ажиллагаа нь шүүгчийн дотоод итгэлээр хэрэгжэд болохоор шүүгчийн мэдэлг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, дадлага, хуульд хэрэглэх арга зүй, итгэл үзүүшилтэй шудч хамааралтай. Иймээс ч хуульд “шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрэснэй бодитойгоор харьцуулан үзсний үндсэн дээр, хэрэгт хамааралт, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзэгүү талаас нь, өөрийн дотоод итгэлээр үнэлнэ² гэж заажээ. Дотоод итгэл нь хуульд зассан арга журмаар цуглуплж, бэхжүүлсан бух нотлох баримт нь тухайн хэрэгтэй хамааралт, ач холбогдолтой, хамгантай, үнэн зөв, эргэлзэгүү байдлыг бүхэлд нь хянан үзсэнээр тодорхойлгодно.

Шүүх хуралдааны үед хэргийн оролцогчид нотлох баримтыг үнэлүүлэх тухай өөрсдийн санал, хүснэгтээ гаргах, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал татгалзан ч ногеет тал нь түүнийг иш татах эрххуулиар олгогдсон байдал. Энэ эрхийг зарим судлаачид, хуульчид тайлбарлахаада нотлох

баримтыг үнэлэх ажиллагаанд тэднийг оролцож байгаа халбар гэж үздэгтэй санал нийлхгүй байна. Харин нотлох баримтыг шүүх шинжлэн судлах ажиллагаанд оролцож байгаа хэлбэр мен.

Шүүгчид нотлох баримтуудыг үнэлэхээс харж авагдсан нотлох баримтад тавигдах шаардлагыг хангасан нотолгооно хэрэгслийдийг хооронд нь харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг танин мэдэхүйн тус бүрийн аргутайд хэрэглэж шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох сурхай хэрэгтэй. Ингэж чадваас шудчийн шийдвэр маань үнэн бодитой, шударга, ойлгомжтой болно.

Нотлох баримтыг үнэлэх явцад гэм буруу нь тогтоогдхүүг, эргэлзээтэй байх явдал гардад. Ийм нэхцэдээр эрүүгийн эрх зүйд, хэргийг хамгантай шалгасан боловч гэм буруу нь нотлогдохгүй эсхүл эргэлзээтэй бол гэм буругуулж тооцно³, шүүгчагчид ашигтайгаар шийдвэрлэн⁴, иргэний эрх зүйд нотлогдохгүй бол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно гэсэн зарним үйлчилдэл.

Мөн л захирагааны хэргийг хамгантай шалгаж, нотлох баримт цуглупласан болоч нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзэл, түрвадагч этгээдийн голмод, хүснэгт нотлогдохгүй өөрөөр эхлбэл, нотлох баримтад үнэлэл, дунголт очг хэргийг тэсг шийдвэрлэх боломжийг болох явдал тохиолдно. Ийн нэхцэлд байгаа нотлох баримтыг үнэлж хэргийг шийдвэрэж болох хоёр арга/ХБНГУ, Франчи улсын шудчийн практикаас хараадаа байдал байна.

1. Захирагааны акт нэхэмжлэгчийн эрх ашигийг хангах, хамгаалахад чиглэсэн, ашигтай

байхаар гарсан нэхцэлд ямар нэгэн хэмжээгээр уг ашигтай байдлыг ашиглах, ашигтай байдалд хамааргахаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх нотлох баримтыг хамгантай хэмжээгээр цуглупласан болоч нэхэмжилж нь нотлогдохгүй байвал нэхэмжлэлээ нотолж чадвагүй гэж үзж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгодог.

2. Захирагааны акт эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохирсонос, дордруулсан гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гарсан тохиолдолд хэрэгт авагдсан нотлох баримтад захирагааны акт үндэслэлтэй эсээл үндэслэлгүй эсээ нь бүрэн тогтоогдохгүй байгаа нэхцэлд нэхэмжлэлийн шаардлагыг хулаэн авч захирагааны акт тухайн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрсөн гэж үзж шийдвэрлэж болох юм. Өөрөөр хэлбэл, захирагааны багцгууллага, албан тушаалтан нэхэмжлэлийн шаардлагыг няцааж чадаагүйтэй адилтаж байгаа хэрэг болно.

Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэхээд дээрх аргыг заавал хэрэглэх ёстай гэж шүүгчэд зөвлөж байгаа юм биш. Гэхдээ Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нотлох баримтыг бүрдүүлэх, цуглупах, шинжлэн судлах эрхийг өргөтгэсэн нь ямар ч тохиолдолд хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэлж, бодит үнэндэг тогтоо замаар шударга ёсны заримд нийцүүэн шийдвэр гаргах боломжкууд байдал гэдгийг харуулсан зорилготойгоор дээрх актых толилуулсан болно.



¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /Ерөнхий ангий/. УБ., 2004 он. 108 дахь тал.

² Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйл.

³ Монгол Улсын Үндэсний хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дахь заалт.

⁴ Монгол Улсын ЭБШХ-ийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт.

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянах ажиллагаа

**Нэг. Шинээр илэрсэн нөхцөл
байдлын тухай ойлолт**

Шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг язь бүрийн шалтгааны улмаас дахин хянах шаардлага гардаг. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа хэргийн оролцогч ба шүүхэд мэдгээгүй, мэдгэдэл боломжийг байсан нөхцөл байдал илрэч болно. Талуудад хэргийн мэдгээгүйг байсан нөхцөл байдлын шинээр илэрсэн нөхцөл байдал гэнэ¹ гэж Оросын эрдэмтэн М.С.Шакарян үзсэн ба энэ шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг хянах журмыг 2002 онд батлагдсан Иргэний хэрг шүүхэд хянах шийдвэрлэх тухай хууль /цаашид ИХШХШТХ гэх-/ийн 17 дугаар бүлэгт заажэс.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхээс хянах объектод дараах эрх зүйн акт хамаараан. Үүнд:

1. Анхны шатны шүүхийн /сум, сум дундын, дүүргийн/ шийдвэр;

2. Давж заалдаж шатны шүүхийн /аймаг, нийслэлийн/ магадлал;

3. Хяналтын шатны буюу Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын хураалдааны тогтоог;

4. Дээд шүүхийн нийт шүүчийн хураалдааны тогтоог.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллахаа нь хэргээ хянах шийдвэрлэх ажиллагааны бие даасан, онцгой уе шат гэж үзүүлж бөгөөд энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийн хууль ёсны ба үндэслэлтийг болсон эсэхийг шинээр



**МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн ахлах багш,
докторант Д.Хуяг**

илэрсэн нөхцөл байдалтай холбон авч үздэг ба хэргийг хянах үндэслэл, хянах журам нь бусад уе шатаас онцлогтой байдал.

**Хоёр. Шинээр илэрсэн нөхцөл
байдлын улмаас шүүхийн
шийдвэрийг хянах
үндэслэл, онцлог**

ИХШХШТХ-ийн 179 дэээр зүйлд Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах 4 үндэслэлийн нарийн заажээ. Үүнд:

1. Мен хуулийн 179.1.1-д "шүүхийн шийдвэр гарах уед хэргийн оролцогид мэдгээгүй буюу мэдгэдэл боломжийг байсан нотлох баримт илэрэвэл хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас "ханана" гэжээ. Энэ үндэслэлийг Улсын дээд шүүхийн 2002 оны 7дугаар сарын 24-ийн

едрийн 263 дугаар тогтоопын 35 дахь заалтаар² "Иргэний хэрг хянаан шийдвэрлэх уед зохигч, гуравдагч этгээд буюу тэдний төвлөлгүүд, эмчилгүүд мэдээгүй, мэдэх боломжийг байсны улмаас шүүхэд гаргаж өгөгүй, түүнийг бурддупх талаар хүснэгт тавигчийн улмаас шүүх хуульд заасны дагуу гаргуулж аваагүйгээ шалтгаалан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд мэдгээгүй бөгөөд мэдэгдэх боломжийг байсан, тухайн хэргийн хувьд шинэ нөхцөл байдал тогтоосон нотлох баримт шүүхийн шийдвэр гарсны дараа илрэч мэдэгдсэн нотлох баримт нь шинэ нөхцөл байдал тогтоосон нотлох баримтад хамаарахгүй. Энэ тохиолдолд хэргийн оролцогчид шүүхэд дахин нэхэмжлэл гаргаж маргаанаа шийдвүүлж боломжтой.

Б. Энэ шинээр илэрсэн нөхцөлийг тогтоосон нотлох баримт нь тухайн хэргээг ач холбогдолтой, шүүхийн шийдвэр гарах үндэслэл нь болсон, тухайн нотлох баримт байгаагүй бол шүүх хэргийг өөрөөр шийдэж байсан, маргалдах байгаа талуудын хоорондын харилцааг тодорхойлсон нотлох баримт байх ёстой. Жишиг нь: Туяа, Сайханаа нар охин дүү Норжмаад холбогдуулан хариуцагчийн эзэмшик байгаа өвлөгэхэд эд хөрөнгийг бүгд хууль ёсны өвлөгчид чадир адил хэмжээгээр хуваалгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, шүүх нэхэмжлэлийг хэлэлцээд

¹ Гражданское процессуальное право, России. М., 2002г., под ред. М.С.Шакарян, глава 23, С.487.

² "Иргэний хэрг шүүхэд хянаан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай". Төрийн мэдээлэл 2002.9.28, №36, 1173 дахь тал.

³ Д.Баярсайhan Эрх зүйн олонномодоо факт гэдэг нь "чурал тохиолд" гэсэн утгатай үг гээд Эрх зүйн харилцааг үзүүгээ, өөрчлөх, дусгавар болгоход чиглэсэн нөхцөл байдлын хууль зүйн факт гээн гэж тодорхойлжээ. УБ., 1996 он, 56, 57 дахь тал.

өвлигдех эд хөрөнгийг гурван тэнцүү хэсэгт хуваан талуудад олгоохор шийдвэр гаргажээ. Тэтэл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа явлуулэгч буюу талийгаач эх нь бүх эд хөрөнгөе хуулын ёсны өмчлөгч бус этгээд болох Солонгоод гэрээслэл сан болохыг дээр хууль ёсны өмчлөгч гуравт нотариатыг мэдэгдсэн байна. Энэ тохиолдолд Иргэний хуулийн 522.3 дахь хэсгийн дагуу урьд нь хувваарилсан эд хөрөнгийг Солонгоо хөрнүү нэгжиг нь авах, үлдэх хэсгийг дээрх хууль ёсны өвлиг болох Туяа, Сайханаа, Норжмаа нар адил хэмжээгээр хувваах авах нэхцэл байдал үүсч байгаа тул сүндэрлэсэн гэрээслэл нь шинээр илэрсэн нотлох баримт болно.

2. Шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч байсан нь шинээр илэрсэн нэхцэл болно. Энэ нь:

А. Гэрчийн мэдүүлэг хуурамч байсан;

Б. Шинжээчийн дүгнэлт хуурамч байсан;

В. Орчуулга худал ташаа байсан;

Г. Эд мериийн баримтыг хуурамчаар үндэслэн /сольсон, нусан, гэмтээсэн;

Д. Бичмэл нотлох баримтыг хуурамчаар бурддүүлсэн /жишиэ нь хэргийн хохигч бичмэл нотлох баримтыг засварласны нотариатч гэрчлэхдээс анхааралгүй хандаж хуулагырыг гарчилсан гэх мэт.

Баталгаатай буцаан ул дуудагдах аккредитивийн хэлбэрийн давуу тал нь худалдагч аккредитив нээгч болон баталгаа гаргагч хөөр банкны баталгаагаар хангагдах ба аккредитивийн нөхцөлтэй уялдуулан вексельд инкасс тавих, хямдруулж зарах зэрэг ажиллагааг эрхэлн. Давхар баталгаа сонгосон бол худалдагчийн зүгээс баталгаа гаргагч банкинд үний дүнгийн тодорхой хувийн намэгдэл хураамж төлдөг.

Практикт дээрх хэлбэрийг хэргэлж гол шаардлагыг нь:

> Аккредитив нээсэн банкны санхүүгийн чадвар

> Тус банк байрлаж буй улс орны эдийн засаг, улс төрийн байдал зэрэг юм.

Төлбөр тооцоог гүйцэтгүүлжээс буцаан ул дуудагдах аккредитивийг сонгосон бол энэ нь баталгаат болон баталгаагүй буцаан ул дуудагдах аккредитив гэж хөөр ангилаад.



Гэвч манай улсын зарим арилжааны банкуудын аккредитив журamtай танилцах явцад аккредитивийн дээрх хэлбэрийн талаарх ойлголт нэр мөр тогтолцоогүй байгаа нь ажиглагдаа. Эдгээрийн ялааг тодорхой гаргаагүйгээс үүдээд аккредитивийг буцаан ул дуудагдах аккредитив, буцаан ул дуудагдах аккредитив, баталгаатай аккредитивийг хэргэлжээд илүү тохиомжтой. Өөрөөр хэлбэл, тухайн нийлүүлж буй бүтээгдэхүүн нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох эд юмс байгаа тохиолдолд хэргэлэх ба энэ нь худалдан авагчийн ашиг сонирхлыг хамгаалана.

Гурав. Хуваагдах ба ул хуваагдах аккредитив /төлбөрийг хэзээ хийх байдлаар нь, өөрөөр хэлбэл, ачилтыг хэзээ хийнсээс шууд хамааралтайгаар/:

3.1 Хуваагдах нь: Гэрээнд

тохиолцсон дуны худалдагчид хэсэгчилсэн ачилт бүрийн дараа төлхийг хуваагдах аккредитивийг төлдөрхийлжээ.

3.2 Үл хуваагдах нь: Бүх ачилт дүссэн дараа худалдагчид холбогдох үнийн дүнг төлхийг ул хуваагдах аккредитивийг гэдэг. Үүний ихэндээз технологийн хувь нь янголаа холбоотой тоног төхөөрөмж нийлүүлэхэд ул хуваагдах аккредитивийг хэргэлжээд илүү тохиомжтой. Өөрөөр хэлбэл, тухайн нийлүүлж буй бүтээгдэхүүн нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох эд юмс байгаа тохиолдолд хэргэлэх ба энэ нь худалдан авагчийн ашиг сонирхлыг хамгаалана.

¹ ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994. Article 8a

² ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994. Article 6.c

³ ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994. Article 9a

Аккредитивийн төрөл:

Олон улсын банкны практикт яңа бүрийн аккредитивийг бий болгох түүнийгээ тодорхой төрлүүдэд ангилдаг байна. Эдгээр төрлүүд нь санхүүгуулэх эх сурвалжаараа мөн тухайн үргийг гүйцэтгэх оролцгын эрхээр ялаатай байдал.

Аккредитивүүдийн хослол болон аккредитивийн төлбөрийн хэрхэг тухай тусгай тохиолцоо хийж болно. Тухайлбал:

- Баримтаар шууд төлбөр хийх аккредитив;
- Хугацаанд нь төлбөр хийх аккредитив;
- Акцептгаар төлбөр хийх аккредитив;
- Урьдчилгаа зээл бүхий аккредитив;
- Нөгоцийний аккредитив;
- Сэргээгдэх аккредитив;
- Шилжих аккредитив зэрэг төрөл байна.

Баримтаар шууд төлбөр хийх аккредитив

Хамгийн өргөн хэрэглэгдэг аккредитив бол баримтаар шууд төлбөр хийх аккредитив юм. Энэ тохиолдолд аккредитивийн нэхцэлт хангагдсан бол баримт хүлээн авлагч худалдаачид төлбөр хийж ёстай. Хүснэгтэд тэмдгэлэдэн L/C гэдэг төвлөрч нь Олон улсын хэмжээнд харгалзгадгэж аккредитив (letter of credit) гэсэн үг юм.

Банк тухайн баримтуудыг хүлээн авсанас хошой банкны ажлын 7 хоног хурталь хугацаанд тэдгээрийн хянан шалгадаг.

Үнийн дүнг худалдагчийн дансанд хийж оруулах өдөр нь уг аккредитив ямар валютар нэхдэнсэнээс хамаарна. Нэхамжлах валиут нь худалдагч, худалдан авагчийн орны албаны нь биш бол аккредитив нээгч банк тухайн валиут хамаарах орны ямар нэгэн банкнайд уг мөнгийг харилцагч банкныхаа дансанд оруулах эсвэл нэхэмжлийн дагуу гүйвуулга хийж эрх олгодог.

Хугацаанд нь төлбөр хийх аккредитив

Аккредитивийн энэ нэхцэлвэр худалдаач баримтаа банкнайд өгсөн дор нь биш баримтын аккредитивтэй заасан тодорхой хугацаа энгэрийн дараа төлбөрөө авдаг. Худалдаач шаардагдах баримтын хүлээлгийн өгөхдөө хугацаа нь боломж төлбөрөө авах тухайн банкны баталгаа бичгээр авдаг. Ийм замаар худалдан авагч нь тухайн аккредитивийн дагуу дунг дансаасаа хасуулахаас өмнө баримтын барагаа буюу ажил үйлчилгээ/ зэмшигээс эрхтэй болно.

Эдийн засгийн утгаарыа хугацаанд нь төлбөр хийх баримтын аккредитивтэй төлбөр хийх аккредитивтэй адил боловч энэ аккредитивтэй векселийг оролцож байхгүй ууир уг аккредитивийг хөнгөлөлттэй үзээр борлуулан тэр даруй мөнгөө авч болгогүй. Харин зарим тохиолдолд банкны төлбөрийн баталгаа нь урьдчилгаа авахад барьцааны үүргэг гүйцэтгэж болно. Гэвч ийм урьдчилгааг зөвхөн аккредитив нээгч буюу давхар баталгаа гаргагч банкнаас авч болно.

Акцептавар төлбөр хийх баримтын аккредитив

Энэ аккредитивийн төлбөрийг аккредитив наэгч буюу наймаалцлагч эрх бүхий банкны нар дээр бичигдэн хугацаат векселийн хэлбэрээр гүйцэтгэдэг. Худалдаач аккредитиваараа хүлээсэн үргээг нэгэнтэй биелүүлсэн бол векселийг акцептэлж юерт өвгүүлж эхийг шаардах болно. Ингэж акцептлэгдсан вексель бэлэнээр хийх төлбөрийг орлоно.


Акцептлэгдсан векселийн хугацаа боломж худалдаач өврийн банкнид өгч төлбөр авах буюу мөнгө шууд авахыг хувьз векселийн хөнгөлөлттэй үзээр борлуулж болно. Хялбарыг бодож худалдаач гол төлөв акцептлэгдсан векселийг оролцож банкуудын аль нэгэнэх хадгалуулдаг. Акцептавар төлбөр хийх баримтын аккредитивийн нэхцэлвэр үйлдсэн вексель энхилюул 60-180 хоногийн хугацаатай байна¹.

Акцептгаар төлбөр хийх аккредитив нь худалдан авагчид төлбөрөө авч болгогүй. Худалдаан авагч төлбөр хийх хугацаа болхоссно эмчилеэ бараагаа борлуулж чадвал тэрээр орлогодоо векселийг төлхөд ашиглаж болно. Ийм замаар тухайн арилжааг санхүүжүүлэж зориулж зээл авах шаардлагатай болно.

Урьдчилгаа зээл бүхий аккредитив

Аккредитивийн энэхүү нэхцэлвэр худалдаач урьдчилан тохиолцсон тодорхой хамжээний мөнгөн урьдчилгааг харилцагч банкнаас авах боломжтой. Энэхүү урьдчилгаа нь тухайн аккредитиваар нийлүүлжтэд бараат үйлдвэрлэх, худалдаан авахад зарцуулагдана. Худалдаач урьдчилгаа авлагч энэ тухайгаа баримт үйлдэж аккредитивийн хүчинтэй хугацаа дусахасаа өмнө шаардагдах баримтыг бурдуулж ехж тухай амплант бичгээр өгнө.

Урьдчилгаа харилцагч банк төлөх боловч хариуцаж эзэн нь аккредитив нээгч банк болно. Худалдаач шаардагдах баримтыг хугацаанд нь бурдуулж өгөвсүү, урьдчилгааг буцсан төлж чадажгүйд хүрээл харилцагч банк зохиц хүчиний хамт аккредитив нээгч банкны данснаас хасна. Аккредитив нээгч банк худалдан авагчадас уг мөнгийг талтуулж авах тул худалдаан авагч урьдчилтаа болон түүний хүчиний эрсдэлийг хариуцдаг байна².



¹ Credit Suisse, "Documentary credits, documentary collections, bank guarantees", 1994, P.41.

² Credit Suisse, "Documentary credits, documentary collections, bank guarantees", 1994, P.43.

Харилцагч банкинд урьдчилгаа олгох зөвшөөрлийг улаан бэхжэр бичдэг байснаас үүдэн зарим тохиолдолд улаан нөхцөлт аккредититээ гэсэн нэрийг хэрэглэх явдал байдал.

Гэхдээ улаан нөхцөлт аккредитивийн үед тодорхой хэмжээний аз түршилт байдал. Тодруулбал, худалдагч мөнгийг нь авчихаад барага нь ачуулахгүй байх явдал тохиолдолд. Гэхдээ дээрх рискийн ногоон нөхцөлт аккредитивийг нээх замаар багасгах болдог. Ногоон нөхцөлт аккредитив нээгдсэн үед улаан нөхцөлт аккредитивийн арга худалдагчид урьдчилгаа төлөх боловыг энэ нь тухайн баараа агуулахад хадгалагдаж буйг баталсан агуулахны орлогын баримт /квитанц-/аар баталгажсан байдал. Агуулахын орлогын баримтыг хадгалагдай баараагаа үнийн дүнг үндэслэн зөвхөн агуулахаас олгодог журамттай. Эрсдэлтэй хагасган энэхүү нөхцөлийг хэрэглэж байгаа тохиолдолд харилцагч банкинд урьдчилгаа олгох зөвшөөрөл дээр ногоон бэхжэр тэмдэглэл үйлддэг байна.

Негоциацийн баримтын аккредитив

Negotiation гэдэг нь наймаалцах эрх олгогдсон банк худалдагчийн үйлсийн вексель ба /бууу баримтад үнзлэгээ хийхийг хэлнэ. Баримтад үнзлэгээг төхөнгөйгээр зөвхөн тэдгээрийт шалгахыг негоциац гэж үзүүхийг¹.

Вексель буюу баримтадыгүй нийхий төлбөр нь худалдагчийн

хүлээлгэн өгсөн баримтууд зөрчилгүй байх тохиолдолд аккредитив нээгч банкны зүгээс баталгаатай байна. Негоциацийн аккредитивийн хамгийн түгзэмэл холбар нь аль ч банкинд ногоциац хийхийг зөвшөөрсэн байдаг. Зөвхөн цөөн тохиолдолд сонголтыг зарим тодорхой баанкаар хязгаарлана. Негоциацийн аккредитив төлбөрийн комиссыг худалдагч төлдөг. Үүгээрээ аккредитивийн бусад хэлбэрээс ялгатай².

Сэргээгдэх аккредитив

Энэ аккредитив нь худалдагч, худалдан авагч нарын хооронд үед хэдэн гэрээ хэцүэлийг санхүүжүүлэхэд чиглэнэ. Тухайлбал, нэг гэрээ хэцүэлийн үед олон ачилт хийн, эсвэл цаасид угрэлжлэх олон талын гэрээ хийгдсэн үед төлбөрийг түртгэхийн түнд дээрх хэлбэрэйн аккредитив илүү тохиомжтой. Аккредитив ашиглалын нийт хугацааны дотор худалдан авагч аккредитив нээсэн банкинд худалдагчид төлсэн төлбөрийн дүнгээр аккредитив нөхөн сэргээглэхийг сэргээгдэх аккредитив гэдэг.

Энэхүү аккредитив нөхцөлийг, бараг тэнцүүхэн хэмжэээр тодорхой үеүлэлтийээр нийтийнхүүлах нөхцөлд хэргэгднэ. Тухайлбал: "Аккредитивийн дүн 100.000.00 төгрөг, цаасид 1.200.000.00 төгрөг хүртэл 12 удаа давтагдана". Энийн 100.000.00 төгрөг ашиглагдаж дусмынц дараачийн хэсэг нь аяндаа хүчинтэй болж давтагдсанар нийт дүн 1.2 сая төгрөг болтол түргэлжилнэ. Давтагдах тухай

заалтад ихэнх тохиолдолд ямар хугацаанд аккредитив ашиглагдахыг мөн заах өгдөт.

Сэргээгдэх аккредитив нь нэмэгдэх буюу ул нэмэгдэх хэлбартэй байж болно. Нэмэгдэх гэдэг нь ашиглагдаагүй буюу дуту ашиглагдсан хэсэг нь даравчийн учелзэл шилжихийг хэлзэх ба ул нэмэгдэх гэдэг нь тухайн учелзэл ашиглагдаагүй хэсэг нь хүчингүй болж цаашид ашиглагдаагүй болохыг хэлнэ.

Шилжих аккредитив

Шилжих аккредитив нь хинжнэн худалдаагүй нэг буюу түнээс дээш байх боломжтой байдал. Уг аккредитив нээгдэх үед эзэмшигээрийг шилжүүлэх үүний эзргээсээ болж болох уурт, хариулагыг мөн шилжүүлнэ. Аккредитив нээгдсэн банкнаас аккредитивийн маягтын дээд бууланд "Шилжих аккредитив" гэж бичсэн байх шаардлагатай байдал.

Шилжих аккредитив нь ерөнхий зохицуултаараа нэг удаа шилжих боломжтой гэхдээ хэдэн удаа шилжүүлэх талаар ямар нэг хязгаарлалт тавигүй.

Худалдагч, бэлтгэн нийлүүлэгч хөөр нь нэг этгээд бус байж үед энэхүү аккредитивийг хэрэглэдэг.

Аккредитив нөхцөлийн холбэр, төрлийн талаар UCP500 болон бусад холбогдох материалд түшиглэн төвчкон байдлаар тайвартархыг хичээлээ. Манай улсын арилжаны банкуудын хувьд эдгээр холбэр, төрлийдээс хэрэглэж эхлэж байгааг тэдгээрийн аккредитив журмаас харж болно.



¹ ICC Uniform Customs and Practice for Documentary Credit. 1993 revision in force as from 1 January 1994. Article 10e-ii


² Credit Suisse, "Documentary credits, documentary collections, bank guarantees". 1994, P.44.

Японы эрх зүйн тогтолцоо ёд түүнч шүүхийн жишгийн эзлэх байр суурь

Миний бие энэхүү судалгааны ажлын хэсэгтэй Японы эрх зүйн тогтолцооны сонирхол төрөм түүх, мен жишгийн эрх зүйд Япон улс хэрхэн хандах буй талаар К.Цвайгерт, Х.Кетц, Х.Ода нарын эрдэмтдийн бүтээлд тулгуурлан харьцуулсан эрх зүйн түүднээс төвч дурдахгүй зорилоо.

Японы эрх зүй нь Харьцуулсан эрх зүйн объект болох нь

Японы эрх зүйн түүх, хөгжил, эрх зүйн эх сурвалжийн онцлог шинж чанартай танин мэдэх туслам судлаачид Японы эрх зүй нь бусад улсын эрх зүйгээс ялгаргдан олон төрлийн онцлог шинжтэй, судалгаанаа маш өргөн объект болохыг харж болно. Ялангуяа, эрх зүй дөнгөж хөгжин цэцгэлз шатандaa явж буй монголын хувьд нэг бус нутагт шашин, уламжлалын ойролцоо хувь загвартаар оршинаас тогтох бүй улсынхаа эрх зүйг судалж, харьцуулж авах, гээх нь нэн чухал. Ийн харьцуулсан судлаах нь сёёл, уламжлал, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн хувьд харьцаангуй хол барууны эрх зүйн сургаалиг шүүд Монгол хөрсенд буулгахас илүү ачхонбогдолтой юм. Нөгөө талаас, японы эрх зүйн түүхийн хуримтуулсан түршилгаа монголын эрх зүйн хөгжилд сурх бичгийн нэгэн адил гарах гарц, олж шийдвэр болох билээ. Японы эрх зүйчид түүхийн өрнөл явцад олон эрх зүйн бүлүүдээс суралцаж, өөрийн эрх зүйн тогтолцоог дотоодын болоод хөндлөнгийн сонирхлын хувьн зүйлсийн нөлөөллөөр бүрдүүлсэн нь яах аргагүй Японыг харьцуулсан эрх зүйчид сонирхон судлах хөрс дэвсгэр болж егдэг. Мен шүүхийн жишгийн хэрэглээ, түүнийг зохих



ХҮҮТ-ИЙН ЭРДЭМ
ШИНЖЛГЭЗНИЙ АЖИЛТАН
Б.Гүнбильт

түвшинд хүлээн зөвшөөрсөн байдал нь Монголын эрх зүйчийн анхаарлын төвд байх ёстой асуултуудын нэг мөн гэж үзж байна.

Бидний мэдэхээр авран есдүгээр зууны сүүл үеэс эхлэн Европын болоод АНУ-ын эрдэмтэд харьцуулсан эрх зүйг сонирхж эхэлсэн юм. 1869 онд Францад *Societe de legislation comparée* буюу Харьцуулсан эрх зүйн анхны нийтэмлэг дэлхийд бий болсон хэдийн чихэндээс англи-америкийн ба эх газрын эрх зүйн тогтолцоог харьцуулсан судлахад гол анхаарлаас хандуулж байв. Гэхдээ энэхүү хөөр тогтолцооны гадна орших тогтолцоонуудыг нэг мөр угүйгэсэнгүй. Зарим нэг судлаачид Европын эрх зүйн тогтолцооны гадна орших улсуудын эрх зүйг өөрийн судалгааны ажилд хамруулжээ. Тэдээрийн нэгд Япон зүй ёсоор орж байсан ч харьцуулсан эрх зүйн гол төвүүд

болов Голланд, Франц зэрэг оронд Хятадын эрх зүйн судалгаа илүүтэй хөгжсөн байв.

Япончууд авран есдүгээр зууны дунд үеэс эхлэн өөрийн хуульчдаа Европ, тэр дундаа эх газрын эрх зүйт орнууд руу илгээж боловсров эзэмшиүүлэх болжээ. Мен Европоос эрдэмтэд урин замж, өөрийн зарим хуулийг гадаад хэл дээр орчуулж байв. Жишээ нь, Германы эрдэмтэн Otto Rudolf 1889 онд Tokugawa Shoguna хуулиудыг орчуулсан бол мен үед Ж.Х. Вигмор, дэл Бекер нар японы иргэний эрх зүйн салбаргат ажиллах, гадаад өртөнцөд Японы эрх зүйн тухай ойлголт өгжэх түүхээ болсон юм.² Японы талаас ч Наохира Сугияма, Котаро Танака нарын хуульчид олон улсын болон харьцуулсан эрх зүйн салбарт судалгаа хийж байв.

Дэлхийн II дайны өмнөх үед Европ, АНУ-ын судлаачид Японы эрх зүйг судлах ажил хэсэг зуур үнантанд орсон байна. Гэхдээ энэ нь тухайн үед Японы эрх зүй ба Европ, Америкийн эрх зүйн хоорондын хөгжлийн холбоо зогссон гэж үзж болохгүй юм. Энэ нь зөвхөн тухайн үеийн улс төрийн байдлаас шалтгаалсан хэрэг байв.

АНУ-ын хувьд дайны үеэс эхлэн Японыг эзлэх бодлогоо хөргижуулэхийн тулд японыг маш олон талаас нь судалж эхэлсэн ба судалгааны томоохон салбар нь эрх зүй судлан байсан гэж хэлж болно.

Харин дайны дараах үеэс эхлэн Японы эрх зүйн судалгаа харьцуулсан эрх зүйн салбарт идэвхтийн хөгжлийн эхлэв. Энэ нь Японы гадаад харилцаа хурдацтай хөгжик, мөн эдийн засгийн хувьд хүчирхэгжсэнтэй холбоотой юм.

¹ T. Gorai, 'Influence du Code Civil français sur le Japon', in Le Code Civil: Livre du Centenaire. Paris 1904, P. 783-784. (HIROSHI ODA, JAPANESE LAW 1).

² A. F. Schnitzer, Vergleichende Rechtslehre. Basel 1945, P.271-272.

Японы эрдэмтэн Хироши Одагийн үзэж байгааар Дэлхийн II дайны давваа дэлхийн харьцуулсан эрх зүйгэд гурван шинэ терлийн судалгааны сэдвээт ихээжэн анхаарал тавих болсон байна. Нээдүүзэрт, зүн европын орнууд болон Хятад зөвлөлтийн эрх зүйд багтах болж, социалист эрх зүйн бүл хүрээгээс тэлж дэлхийн томоохон эрх зүйн булийн нэгд тооцогдсан учир. Хөөрдүүгаарт, гуравдагч аргент цэх нарлагдсан орнууд буюу хуучин колони байсан орнууд тусгавар тогтоож, эх газрын болон нийтгэл эрх зүйн булийн аль алины шинжийг өөртөө багтаасан өвөрмээ шинэ терлийн эрх зүйн тогтолцоонууд үүссэн учир. Гуравдүүгаарт, Холбоотон гүрнүүдэд эзлэгээд Японд эрх зүйн шинэ тогтолцоо бий болгос явдал харьцуулсан эрх зүйчдийн гол үргүйн нэг болсон юм. Ингээний түд Японы угуул эрх зүйг судлах шаардлага өндөр байв. 1980-аад онд Японы эдийн засаг маш их хүчирхэгжээснэр зөвхөн хувийн эрх зүйд төдийгүй, соёл, түүхийн салбартаа Японын дэлхий дахин сонирхол болжээ.

Хэдийгээр Луизиана зэрэг зарим мүжийг эс тооцвол АНУ нийтгэл эрх зүйн бүнд баатгахадийн ч еренхийдээс эх газрын эрх зүйд тооцогдож болох Японы эрх зүйн тогтолцооноос хөгжилд АНУ-ын судлаачид маш их хувь нэмэр оруулсан юм. Харьцуулсан эрх зүйн хүрээнд Японын судлах ажилд АНУ хамгийн их ач холбогдол агсан гуран ба Артур фон Мэрэйн хянан тохиолдуулсан *Law in Japan: The Legal Order in a Changing Society* буюу чиглэлблэл Япон дахь эрх зүй: *Өөрчлөгдэв бүй нийзэмд дэх эрх зүй төлөв* гэдэг 1963 оны бутазл нь Японы харьцуулсан эрх зүйн хүрээнд гаргасан хамгийн анхны бүтээлдүүдийн ногд тооцогддог. 1967 онос япон, америкийн хуульчид хамтран *Law in Japan* буюу Япон дахь эрх зүй сэтгүүлийн жил бүр хэвлүүлж эхэлжээ.

1970-аад оны үеэс германчууд, ялангуяа Хамбург,

Фрайбургэд Японы эрх зүйг сонирхон судлах болсон төдийгүй ихэндээс японы хуульчдын бичсэн японы хуулийн ном, бутээлүүд *Japanisches Recht* буюу Японы эрх зүй нэртэйгээр жил тутмын хэвлэлээр нийтлэгдэх болов. Мен Япон, Германы хуульчдын холбоноос эрхэн *Zeitschrift fuer Japanisches Recht* буюу Японы эрх зүйн тухай сэтгүүл нэртэй сэтгүүл гарч эхэлжээ.

Улааны Австралийн их дээд сургуулиудад Японы эрх зүй нэртэй хичээл эзлэх эзэлж байна.

1980-аад онд гарсан *Doing Business in Japan* буюу Японд бизнес эрхэлж нь нэртэй 10 бори ном хэвлэгдсэн нь гаадаа орнуудад японы хувийн ба захирагааны эрх зүйн талаарх маш сайн сурталчилгаа болсон юм.

Японы эрх зүйн түүх

Энэтхэг-Хятадын бусийн болон Солонгос зэрэг азийн улсуудын нэгэн адил Япон улс нь эртнээс хятадын соёлт иргэншийн нөлөөнд оршиж ирсан юм. Хятадын бичиг, усг манай эриний тогтнагаар зуунд. Буддизм зургадугаар зуунд Японд дэлгэрчээ. Манай эриний долоо, наймдугаар зууны Японы эзэн хаад нь хятадын уран зохиол, соёлын олоплын талаарх өндөр мэдлэгэтийн хүмүүс байсан ба тэд версийн төрийн захирагааг Хятадын төрийн хэлбэрээр зохион байгуулж, эзэн хаад бол хэмээгүйгээр эрхт, бүхийн чадагч хэмээн тунхаглаж, төрийн шатлан захирах тогтолцоог бий болгож чадсан байна. Энэ үед биданд байгаа Японы хамгийн эртний хувь, цээс нь Хятадын Танг улсын хувийн тун ижил байгаа юм.²

Удалгуй Японы эзэн хаад буюу Микадо нар өөрсдийн хэмжээгүй эрхээ газрын томоохон эзээс болон эзэлж чадахгүйд хүрэв. Арван хөөрдүүгаар зуунаас эхэн Японы эзэн хаад зөвхөн нэр төдий төрийн тэргүн болон хувирч, өөрсдийн ордоос цүххийхээ байн ард түмнээсээ тасарч эхэлж бол

терийн эрхийг гартаа барьсан удирдагчид нь цэргийн жанжин-Шогун болсон юм. Нээ нелөө бүхий гэр бүлүүд Шогун болохын тулд хоорондоо дайн хийж, улмаар Шогун болсон нь энэ судлаа үр удамдаа уламжлан улдээх хүчин чармайлтын хүчтэй ирэл байв. Иймэрхүү тогтвогрүй, байнгын дайн байдааны байдал арван зургадугаар зууни суул үе хүртэл буюу Токугавагийн гэр бул Шогуны эрхийг барьж эхлэх хүртэл үргэлжилжээ. Токугавагийн гэр бул 1603-1867 он хүртэл Шогуны эрхээ хадгалсан юм. Энэ үед Япон нь бүхэлдээ феодалын нийгмийн бүтэц, аниг давхарын гүн глаанд оршиж байсан ба давхарын хамгийн доод хэсэгт гар үрчудуу ба худалдаачид, тэдний дээр газрын зэдд маш их хэмжээндээ газрын төлбөр төлж байж, газар тариалан эрхэлж байсан тарчид, дараа нь санваартан, эмч, эрдэмтэд, төрийн албан хаагчид, хунтайжийн цэргийн албаттууд багтсан ба энэ ангийн давуу эрхт хэсэг нь самурай нар байв. Японы феодалын нийгмийн хамгийн дээд эрх мэдлэлтэн нь Шогун байжээ. Феодалын ниймжлийн энэхүү, бүтцэд гол тохирох гүн хуаан нь Күнз хэмээн Токугавагийн гэр бул үзж байв. Энэ үед японы шүүхийн тогтолцоо үндсэн хэлбэрээс олж, хувийн эрх зүйн маргаанууд Хятадын адил нийгмийн тодорхой ангиудын дунд (тухайлбал, худалдаачид) нэг мөр өйлгөгддөх хүрч, хэргэлгэж эхэлж байжээ.³

Токугава Шогуны гар бул нэгч япон хүн арлыг орхиж болохуй, мен нэгч гадаад хүн японд ихрэх болохгүй гэсэн японы аль болох аргентцевс таслах бодлогыг хоржкуулж. Гэсэн хэдий ч энэ бодлого нь байгын худалдаа хийдэг Хятад ба мэн маш хатуу болзлын дүнд японы цөн тооны эрэг дээр бараа буулгах эрхтэй Нидерланд улсад үйчиндагтгүй байлаа. Энэ байдал удаан үргэлжилсэнгүй. Арван наймдугаар зууны эзэн үеэз эхэн барууны хөгжлийн зарим олоптыг япончуд хүлээн зөвшөөрч эхэлсэн түү баруунаас зарим төрийн ном, Үйлдвэрлэлийн технологи япончудын сонирхлыг их татаж байлаа. Негээс Японийт

¹ HIROSHI ODA, JAPANESE LAW 2, (2nd ed. 1999).

² K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998) P.296.

³ K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

худалдаа хийх гэсэн барууны орнуудын сонирхол ч маш их байсан юм. 1853 онд АНУ байландааны усан онгоцуудаа Японы эргүүд рүү Японийн худалдааны гэрээ хийх зорилгоо ингэж, анх удаа Шогун "нэг талын сонирхол давамгайлсан" гэрээ хийжээ. Удالга АНУ-ын Англи, Орос, Нидерланд ийм гэрээ хийв. Гадаадынхан хэд хэдэн хотод худалдаанаа төвөө байгуулж, ерсдийн консулын төлөөлөгчдөө Японд байгуулж эхлэв. Шогун ийнхүү байр сууриннаасаа буцаж, гадаадын иргэдээд худалдаа хийх зөвшөөрөл олгосон нь Японы эзэн хаан идэвхтүүг байдлаасаа гарч, териийн эрхийн өврийн гарг шилжүүлэх боломжийг олгосон юм. Шогуны эсэртуулж саргэх дедгэлтэн бий болж, эзэн хаан энэхүү хөдлөлгөөнийг удирдсанараа нэгэнт хүч чадлаад алдан, сүлдорой болсон Шогун 1867 онд эзэн хаанд эрх мэдлээ шилжүүлэв. Эзэн хааны зөвлөхүүд Япон улс гадаадын өндөр хөгжлийг улсустай худалдаанаа гэрээ, хэцүэл хийж, тэдний үйлдвэрлэлийн технологи, шинжлэх ухааны ололт, сийлжээс сурцаах шаардлагатай мэдэрж байлаа. Хуучны үзлэлтэй олон ч удирдагчид түүний тун удалгыг хүлээн зөвшилж, улмаар Япон улс Европын загварт захиргааны болон цэргийн зохион хувьгуулалттай болж, баруунаа техник, технологийг хэрэглэх эхлэсэн ба 1889 онд Үндсэн хуулийн батлав. Үндсэн хуульд зааснаар Эзэн хаан бух асуудлыг шийдэх эрхтэй. Хоёр танхимтай парламенттэй ба парламентийн дээд танхим удам дамжсан язгуултуунд, эсвэл эзэн хаанаас шинээр хэргэм зэрэг хүртгэдээс, харин доод танхим Японы нийт хүн амын хөрхувийг зэлж чинээлж амьдралттай иргэдийн орцлогсон сонгуулиар сонгогдсон төлөөлөгчдөөс бурдаж байв.

Мэйжигийн Үндсэн хууль буюу 1889 онд батлагдсан Японы энэ Үндсэн хууль нь Японы анхны

орчин үеийн Үндсэн хууль юм. Энэ хуульд Пруссын Үндсэн хуулийн загварыг ашиглажээ. Эзэн хааны эрх мэдлэгийг ергесгэж, түүнийг териийн идэвхтэй тэргүүн болгосон хууль ба эзэн хаан нь зарим улс териийн шийдвэрээз үндсний хурлаас томилогдсон албан тушаалтнуудын орцлогтойгоор гаргана хэмээн заасан байна.¹

Гадаад улсустай байгуулсан "нэг талын сонирхол давамгайлсан" гэрээнд зааснаар гадаад улсын консулын газрын шүх нь гадаад, дотоодын иргэдээтийг холбоотой иргэний болон эрүүгийн хэргийг шүүх шийдвэрэлх эрхтэй байсан учраас Японы хуучин шүүхийн хэрэгээ буурав. Иймээс япончууд Европын шүүхийн загвартай ижил шүүхийг байгуулах шаардлагатай тулгарсан юм. Тиймээс тэд Парисаас профессор Бойссонадыг эрүүгийн болон эрүүгийн байсан шийтгэх хуулийн төслийг боловсруулахаа ажилд урьж авчрав. Бойссонад Францын эрх зүйн сургаал нэйт шингэсэн эрүүгийн хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын загварыг бэлтэн 1880 онд батгуулжээ. Үнийн дараа тэргээр иргэний хуулийн төслийг бичиж эхлэв. Харин түүнтэй германы профессор Реслер эзргэцэн арилжааны хуулийн төслийг бичжээ. Бойссонадын иргэний хуулийн өсрүүлийн баалжсан шилдэг хуулиудаар багасганаа шийтгэх хуулиудын загварыг бэлтэн 1880 онд батгуулжээ. Үнийн дараа тэргээр ирилжсан хуулийн төслийг бичиж парламентад хуультай хамт парламентад оруулж, уг хуулид нь 1893 оноса эзэн хүчин төгөлдөр үйлчлэхэр болсон юм.

Гэвч парламентад уг хоёр хуулийн талаар ихэхэн маргаан дэгээр. Маргааны гол садзь нь иргэний хуулийн төслийг дэндүү Францын эрх зүйн үзлэл санаа шингэсэн, бусад орны эрх зүйтэй ер харьцуулаагүй, японы эрх зүйн уламжлал ер тусгагдаагүй хэмээн үзсэнд байлаа. Ингээд гурван профессороос бурдсан японы хуулийн комисс Иргэний хуулийн төслийг дахин няяталж үзэх

даалгавар авав. Энэхүү комисс нь нэн шинэ төрлийн хуулийн төслийг 1896 оны найман сард таницуулсан юм. Францын болон Нийтлэг эрх зүйг энд тэнд бага зэрэг тусгасан болоч Германы иргэний хуулийг бутцаа тулгуурлажээ. Мен гар бүл, өв замгамжилын хэсгийг Японы уламжлалт эрх зүйн зохицуулалтаар зохицуулсан байна.²

Ингээд Германы хуулийг бараг тэр чигт нь хуубарласан иргэний хууль 1898 онд, арилжааны хууль түүний дараа жил хүчин төгөлдөр болов.³ Япончүүд Францын иргэний хууль буюу Code Civil-ийн маш түргэн хугацаанд үүгүйсгэж, германы иргэний хууль буюу BGB (*The Bürgerliches Gesetzbuch*)-г ийнхүү хуулбарлах болсон гол шантгаан нь тухайн үед францын иргэний хуулийн зарим ног техникийн алдаа ил болж, изр хүнд нь унаж байсантай холбон тайлбарлаж болох ба мен нөгөө таалаас германы иргэний хууль эх газрын тогтолцоонаа хамгийн шилдэг хууль хэмээн үзэлгэжээд байсан нь нөвлөлсөн байж болх талтай.

Японы эрх зүй нь БНХАУ-ын эрх зүйгээс баруунаа хуульчдын ардчилсан үзэл, үндсэн хуулийн харилцаа, эдийн засгийн харилцаа чадварлаг зохицуулсан хуулиудаар нэн ялагдтай юм. Өнөөгийн Японы мэдрэх байгаа Үндсэн хууль нь 1947 онд батлагдсан ба түүнээс хойш нэг ч удаа нэмэлт, өөрчлөлтийн хийдэгүйг байна. Үндсэн хуулиар Японы парламентын чиг үүргээ ба хүний үндсэн эрхийдийг хуульчилж өгсэн. Эзэн хааны улсын *de jure* тэргүүн хамзан зарлан тунхагласан ба эзэн хаан нь Японы ард түүний эв нэгдлийн бэлгэд тэмдэг болдог. Дэлхийн хоёрдугаар дайнаас ихээхэн сургамж авсан япончууд хуучин тогтолцоогоо халж, ардчилсан шинэ Үндсэн хуулийнхаа 9 дүгээр зүйлд дайн одоох, дайн хийхийг хатуу хориглож хуульчилж өгсэн байна.⁵

¹ K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

² http://en.wikipedia.org/wiki/Japanese_Constitution (хамгийн сүүлийн 2006.01.27-нд зочилсон).

³ supra note 4 297-298 (supra note 4 гард нь ишлэл 4-т заасан эх сурвалж гасан уг. Цаашид мэн ийнхүү хэрэглэнэ).

⁴ Kitagawa, "Das Methodenproblem in der Dogmatik des japanischen buergerlichen Rechts". AcP 166 (1966) 330.

(K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998) P.298)

⁵ supra note 7.

1945 оны 7 дугаар сарын 26-ны өдөр Дэлхийн хоёрдугаар дайнд ялагч холбоотон улсуудын тэргүүнүүд Уинстон Черчилл, Харри С. Трумэн, Иосиф Сталин нар Японы эрх зүй тогтолцоогөөрвлийн чадахуйц бичиг болох Потсдамын тунхаглалыг баталж, Японы эзэн ханаар түүнийээ хүлээн зөвшөөрүүлж чаджээ. Энэ нь тунхаглал хэмээн нийрийдсэн гэлээ магадгүй дэлхийн түүхэнд тохиосон хамгийн анхны арчилсан ёсны хүлээн зөвшөөрүүлэх тулган шаардах бичиг байсан болж юм. Тунхаглалын 10 дугаар зүйд "Япон улсын засгийн газар нь Японы ард түмний арчилсан ёсны чиг хандлага, шинчлэлтийг бататгаж, түүнд тулгарч болох бүхий л саад тогторыг арилгах ёстай. Үг хэлэх, шашин шүтэх, узэл бодолтой байх зэрэг эрх чөлөө, хүний ундсан эрхүүн нь хуулиар баталгаажсан байна" гэж заажээ. Мөн 12 дугаар зүйд "Холбоотон түүнчүүд эдгээр зорилго Японы ард түмний ашиг сонирхлын дагуу тайван замаар биелж, эдгээрийг засгийн газар нь баталгаажуулсан тохиолдолд алийн болох богоино хугацаанд Японы нутаг дэвсгэр дээрх өөрийн цэргээ буцаан татаж авах болно" хэмээн мэдэгджээ.

Ийнхүү 1947 оны Үндсэн хууль багтлагдах урьдчилсан нөхцөл бүрдсэн ба түүний төслийн боловсруулнах ажилгаанд АНУ-ын хуульчид өргөнөөр оролцсон байна.

Японы эрх зүйн тогтолцоон дахь шүүхийн жишиг

Жишигийг япон хэлээр "сэнрэй" хэмээн нарилдог. Тэр дундаж Японы шүүхийн жишигийг "ханрэй" гэдэг байна.

Японы эрх зүйн тогтолцоо нь өрөнхийдөө бичмэл хуулиадад тулгуурласан байдаг. Гэсэн хэдий ч энэ нь японд шүүхийн жишиг хэрэглэдэгтүй гэсэн уг биш юм.

Ялангуяа Дээд шүүхийн шүүгчид шүүхийн жишигийг үндсэн эх сурвалжийн нэгэнд тооцож, хэрэглэдэг. Шүүхийн шийдвэрээс шинэ зохицуулалтууд байнга шинээр төрх байдал учраас шүүхийн шийдвэрээр судлах явдал нь хууль зүйн асуудлуудыг хэлэлцэрх чухал арга зам болж өгдөг байна. Дээд шүүх болон доод шатны шүүхийн шийдвэрүүдийн тухай эрдэмтэд, практикийн хуульчид тайлбар гаргаж, сэтгүүл, сонин хэвлэлд нийтэлдэг нь хожмын шүүхийн шийдвэр гарах ажилгаанд чухал нөхөн үзүүлэх нь тодорхой юм.²

Дээд шүүхийн ач холбогдол өндөр шийдвэрүүдээс Дээд шүүхийн дэргэдэх Жишигийн Комисс (Precedents Commission) шаардлагатай шийдвэрүүдийг сонгон авч хэвлэлдэг байна. Мен бусад шатны шүүхүүд ийм хэлбэрийн эмхэлэлт гаргадаг.³

Орчин үеийн Японы эрх зүйт хөгжүүлэхдэд шүүхийн үргэл маш их юм. Хүний эрх, газар, ул хөдлөх хөрөнгө, гэм хорыг нөхөн төлөх (tort law) тухай зэрэг зохицуулалтуд нь дан гаанц бичмэл хуулидаас бүрдээгүй ба тэдээрт шүүхийн жишигэр намзлтууд хохицуулалт хийсэн байдаг.⁴

Нийгмийн харилцааг зохицуулж буй бичмэл хуулиуд нь ихээхэн ерөнхий чуир шүүхийн шийдвэр хуулийн цоорхойг нөхөж өгдөг. Жишиг нь гэм хорыг нөхөн төлөх (tort law) эрх зүйт ихэнх улсуудын адил Япон улс Иргэний хуульдаа зааж өгсөн. Иргэний хуулийн 709 дүгээр зүйд заасан тархуу зохицуулалт нь ирээдүйд гарч болох бүхий л нөхцөлгүй тусгасан байх ёстой учир санаатайгаар тун ерөнхий бичигдэсэн. Энэ хууль нь болгоомжгүй байдал, учир шалтгаан, хууль бус байдал газ мөт ойлготгудыг тусгаагүй болочв шүүхийн шийдвэр тэдээрийг

зохицуулж өгсөн байна.⁵

Үүнтэй адил жишиг бид Японы захирагааны эрх зүйгээс харж болно. Захирагааны хэргийн тухай 1962 оны хуулиар зохицуулсан "хориглох үйл ажиллагаа" гэсэн хэсгээ зөвхөн дөрвөн зүйлийг тусгасан ба бусад хориглох зүйл гэдэгт эрдэмтдийн үзэл бодол, шүүхийн шийдвэрүүдэд зориуулан боломж гаргаж өгсөн байна. Тухайлбал, алтаваа захирагааны байгууллагад шаардлагатай агаа хэмжээ авахыг захирамжлах тохиолдол, түүний хүчин төгөлдөр байх нөхцлийг шүүхийн жишигээр зохицуулсан байдаг.⁶

Бичмэл хуулийн дагуу шийдвээн хэрэг заримдаа шудараа үр дүнд хүрч чадахгүй байж болох тул Японы шүүхүүд тэдээрийн хүчийг сууринаж явлад гардаг. Тухайлбал, хөдөлмөрийн эрх зүйн салбарт хангалийтai, нийгмийн шудараа ёсанд нийцсэн шалтгаан угийн тохиолдолд ажил олгогч үндэслэгүйгээр ажилтнууд алваас халах эрхгүй хэмээн жишиглэсэн. Үүнтэй төстэй жишиг үл хөдлөх хөрөнгө хөлслэгч, хөлслүүлэгчийн хоорондын харилцаанд бий. Энэ нь шүүх public order буюу ниймийн дог журмын хэрэгжүүлж байгаа хэрэг юм.⁷

Мен зарим үед хохистхийн үр дүнд хүрэхийн тупд шүүх хуулийн тодорхой заалтаас зоригтой татгалзаж, шийдвэрээ гаргах тохиолд бий. Үүний тод жишиг нь хэв шинжийт нь тодорхойлж болохуйт ул хөдлөх хөрөнгийн эрх юм. Японы Иргэний хуульд тодорхойлсноо вэр нөхцөлбөр үл хөдлөх хөрөнгийг тодорхойлж үл болно" гэсэн зармын шүүх зөрчин налзээд олон шинэ төрлийн үл хөдлөх хөрөнгийн хэлбэрийг тодорхойлж өгсөн байдаг. Үүнтэй адилгаар Дээд шүүх зээлийн зохицуулалтад хэтэрхий их хүү тооцоохор заасан зээлийн гэрээний төлбөрийг хохист түвшинд барьж зээл авагчийн эрхийг хамгаалах тухай жишиг гаргах байв. Зээлийн хүд хягаар тогтоо тухай хуульд зааснаар бол хүүг зээлдэг вөрөө хүлээн зөвшөөрч, сайн дураар төлсөн бол тус төлбөрийг буцааж олгохгүй гэж заасан байдаг.⁸

Японы хуульчдын дунд шүүхийн жишиг нь эрх зүйн эх сурвалж мөн эзэх талаар маш олон язнын үзэл байдаг. Японд шүүхийн

1. K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).
2. *supra note 3*, 50-51, (2nd ed. 1999)

3. K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

4. K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

5. K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

6. K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

7. Hironaka, 'Wagatsuma minpo-gaku to han-seitei-ho-teki kaisaku (Civil Law Theories of Professor Wagatsuma and anti-statutory interpretation of the Civil Code)', part 3, *Jurist* No.1096, 1996, P.74-83

жишиг нь эрх зүйн эх сурвалж мөн гаж шүүд бичсэн албан ёсны шийдвэр, хуулийн заалт байхгүй. Японы Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 3-т зааснаар "Шүүгид ўлж ажиллагаагаа хэнээс ч хараат бус явтуулж ёстой ба зөвхөн хуульд захирагдана". Зарим хүн хуульд шүүхийн жишигийн тухай шүүдээ засваан заалт байхгүй тул шүүхийн жишигийг эх сурвалжид тооцож ёсгүй гэж уздаг. Гэсэн хэдий ч олонхи эрх зүйдийн үзэж байгаагаа шүүхийн жишиг нь эрх зүйн эх сурвалжид тооцгоход ба намзат эх сурвалжийн шинжтэй юм. Учир нь шүүхийн жишигийг шүүч бичмэл хуулийг хэрэглэдэгтэй нэгэн адилар хүчин чадалтайд тооцож, дагаж мөрддэггүй. Өөрөөр хэлбэл, Японы эрх зүй *stare decisis*¹-ийн номполд тулгуурлаагүй юм. Тиймээс шүүх нэгэнтэй тогтосон шүүхийн жишигийг чөлөөтэйшэг өөрчилж болно² гэж үздэг байна.

Харин зарим эрдэмтэн тухайлбал, профессор Кенжи Акашигийн үзэж байгаагаар³ сэнройн хүчин чадал нь Японы Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу үүгүйсгэгдэг боловч, Японы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 1-д зааснаар шүүхийн шийдвэрийн үндсэн гол санаа нь заавал биелгэдхэг хүчин чадалтай байдаг учир хэргийг жишиг хэрэглэн шийдвэрлэх боломж нээлтийн юм. Тиймээс орчин үед Японд шүүхийн жишигийг бичмэл хуулийн тайлбарын шүүхэд хэрэгжүүлж болсон байна.

Япон Улсын Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл зааснаар "Дээд шатны шүүхийн шийдвэр нь доод шатны шүүхийн тухайн хэрэгтэй төсөвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал биелгэдхэг хүчин чадалтай эх сурвалж болно" гээз. Уг хуулийн 10

дугаар зүйлийн 3 дахь заалт мөн уг утга санааг давтан тодорхойлсон байдаг.

Мөн Японы Эрүүгийн Байцаан шийтгэх тухай хуулийн 405 дугаар зүйлийн 2 ба 3 дугаар зүйлүүдэд давж заалдах гомдолд урьд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт өөрөөр шийдвэрлэснийг батлаг буюу шүүхийн жишиг зөрчсөнгийн нотолсон байх тухай заажээ.

Түүнээс гадна Японы хуулийн сонгон шалгаруулалтын асуултад сэнрой маш их хэмжээгээр ашиглагддаг учраас түүнийн ач холбогдол ондёр байгааг харуулж байна гэж хэлж болно.

Доод шатны шүүхүүд заримдаа Дээд шүүхийн тогтоосон жишигийг хэрэгжүүлж байх явдал тохиолддог. Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төвлүүлж, эрх ёв залгамжлагчид ёв залгамжлуулгачийн гэрээслэлээс үл хамаарсан шилжинэ гэсэн утга бүхий зарчмыг Дээд шүүх 1967 онд тогтоосон байна⁴. Гэсэн хэдий ч зарим доод шатны шүүхийн шүүгүүд энэ зарчмыг ихэнх эрдэмтэйдний нэгэн адил хүлээн зөвшөөрхүүг байгаа юм. Тэд ийн холбэрийн нээмжлэх, эрхийг шүүд ёв залгамжлуулж болохгүй, гагчхүү талийгчайчин асран хамгаалж, харгалзан дэмжжэд байсан тэр ёв залгамжлагч л нэхэмжлэл гаргах эрхийг яж үзэн байна.⁵

Дээд шүүхийн шийдвэрлэсэн хэргээс өөрөөр шийдсэн хэд хэдэн удаагийн тохиолдол гарвал Дээд шүүх ёеरийн гаргасан жишигээзэн харахад хүрнэ. Ерөнхийдээ доод шатны шүүхүүд Дээд шүүхийг бодвол бодиждэл илүү ёйр ажиллаж, өдөр тутмын амьдралыг мэдрэж байдаг учраас Дээд шүүхийг бодвол нийгмийн амьдралын өөрчлөлтийг уртаж хардаг байна. Тиймээс тэд Дээд шүүхийн гаргасан тохиомжийг жишигээс татгалзах

бодит үндэслэл дэвшиүүлж чаддаг юм.⁶

Негee талаас, ийнхүү Дээд Шүүхийн гаргасан жишигээс өөрөөр шийдвэр гаргавал энэ нь талдуудын давж заалдах үндэслэл болж болохыг Японы Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн 405 дугаар зүйлийн 2-т заасан байна. Харин Иргэний харэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 318 дугаар зүйлийн 1-т ийм тохиолдол үүсвэл *Certiorari*⁷ үүсч боломжих болно. Тиймээс Японы доод шатны шүүх шинээр жишиг гаргахдаа дээд шатны шүүх түүний хүчинтэй болгож буюу өөрчлэх эрхтэй гэдгийг мэдэж байдаг учраас Дээд шүүхийн жишигийг түлхүү хэрэглэхийг бодлог. Үүний шүүхийн жишигийн заавал дагаж мөрдхөө *de facto* гэж нэхнээд томъёодлог.⁸

Японы Дээд шүүх доод шатны шүүхийн шүүгчийг томилго, ажлаас чөлөөлөх, дэвшиүүлэх эрх бүхий шүүх юм. Иймээс японы шүүгчид хувийн нар хүндээс анхаарч ажиллах шаардлагатай болдог. Тэднийг арван жилийн хугацаагаар томилдог ба мен тэр хугацаагаар сунгана. Харин сунгах баталгaa байхгүй учир доод шатны шүүхийн шүүгчид, аль болох Дээд шүүхэд "таалагдаж" харж гарна. Энэ нь Дээд шүүхийн жишигийг өөрчлөхтүй байхыг хичээж, соорхор дагаж мөрдхөөд хүргэх мүн талтай. Зарим судлаач үүний *stare decisis* номпол, Японд энэ номполд тулгуурласан эрх зүй тогтолцоот улсаас илүү үйлчилхээс нэхцэлийг бурдуйж байна хэмээн шүүмжлэх явалд бай.⁹

Японы шүүхийн жишигийн заавал дагаж мөрдхөө *de facto* хүрээ нь маш өргөн юм. Англи-Америкийн эрх зүйн тогтолцоонд шүүхийн жишигийн үндсэн хүчин чадал нь *ratio decidendi* (жишигийн гол хэсэг)-тээр хэзээрлэгддэг бол Японд шүүхийн жишигийг *ratio decidendi* буюу *obiter dicta* (жишигийн нэмэлт тайлбар

¹ Шүүхийн шийдвэрийг дараагийн төсөвтэй тохиолдолд заавал эх сурвалж болгон дагаж мөрднө гэсэн номпол.

² *supra note* 3, 52.

³ ХБНГУ-ын Макс Планкийн Институтын 2005 оны зочин Японы Кэйо Их Сургуулын хуулийн профессор К. Акашид сэнрой нь Тухай тайлбарлаж өгсөн талархлаа илрүхийлж байна.

⁴ *Judgement of the Supreme Court, November 1, 1967 (Minshu 21-9-2249)*

⁵ *supra note* 3, 52.

⁶ K. Zweigert and H. Kotz, "An Introduction to Comparative law" (3rd Edition, 1998).

⁷ *Certiorari* гэдэг нь доод шатны шүүхээс тухайн хэргийг хэрэн шийдвэрлэсэн тухай зарим нөхцөлийг тодруулж, тайлбар гаргыглал тухай дээд шатны шүүхийн тушалд юм. В.Б.

⁸ T. Nakano ed., *Nanrei no Yomikata* (How to read Cases), Tokyo 1986, P.14-16.

⁹ *supra note* 3, 53.

хэсэг) гэж хатуу ангилдаггүй. Дээд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бий болсон тайлбар, удирдамж нь амьдралдээр доод шатны шүүхэд шүүхийн жишгийн адил хэрэглэгдэж, доод шатны шүүх тэрхүү тайлбар, удирдамжийг өөрийн шийдвэртээ иш татдаг.¹

Японд шүүхийн жишгийн хүчин чадал нь, энэ нь хууль зүйн хүчин чадалтай биш ч байсан, ижил төсөөтэй хэртгүйдийг ижил төсөөтэйзээр шийдвэрлэх гэсэн хэрэгзээний үүдээс хэрэгждэг. Харин Японы шүүхийн шатлан захирах ёс буюу дээд шатны шүүхийн шийдвэрийг доод шатны шүүх дагаж мөрдэх ёстай гэсэн энгийн ойлголтын дагуу хэрэгждэг. Энэ байдлыг Японы Дээд шүүх өөрийн гаргасан шийдвэрээр дагах мөрдэх албагүй гэдгэр тайлбарлаж болох юм.² Өөрөөр холблэл, Дээд шүүх өөрийнхөө гаргасан жишгийг дагах эсэх нь тодорхойтүү үчреас түүнд тэдийн тухайн жишгийг хэрэглэж харгажсаз байхгүй. Тийм учраас доод шатны шүүх ч гэсэн хэрэгцаа гэхээсээ илүү эзгэрт Дээд шүүхийн шийдвэрийг дагах мөрдэх ёстай гэсэн дэгийн үүднээс дагаж мөрддэг байж болох юм.

Дээд шүүх өөрийн гаргасан шийдвэрээр дагаж мөрдэх албагүй гэсэн ойлгот нь терийн захиргааны албан хаагчдын улс терийн үйл ажиллагаанд орцолж орцлоог хягаарлаах тухай хэрэгзэс үүссээ. Тухайблал, Японы Дээд шүүх терийн захиргааны албан хаагчид үлс терийн үйл ажиллагаа явуулсных нь төвөө эрүүгийн хэрэгж татах, яли оноо нь түүний Үндсан хуулиар олгогдоон хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрнич байна гэж үзэн шийдвэрээ гаргаснаас хойш найман жилийн дараа уг шийдвэрээ

еөрчилж, терийн захиргааны албан хаагч үлс терийн үйл ажиллагаа явуулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстай гэж үзсэн юм.³

Энэ нь Дээд шүүх өөрийн урьдын шийдвэрээр хүчингий болгосон анхны тохиолдол болсон бөгөөд харин олонхи хуульчид энэ шийдвэрээр эрх зүйд угийнсэн гэж үзэж байлаа. Гэхдээ энэ шийдвэрэйг гаргасан шүүх бүрэлдэхүүний найм нь урьдын шийдвэрээр хүчингий болгохын төлөө байсан бол тэдэнтэй санал зурсен тав нь Үндсэн хууль тайлбар хийж, шүүхийн жишгийг ийнхүү өөрчлөхдөө маш болгоомжтой хандах ёстай гэж мэдэгдээд урьдны шийдвэрээс хэвээр батлах санал ёштуулж байгаа юм.⁴

Анти-позитивизм Японы эрх зүйн онцлог болох нь.

Дээр хэлсэнчлэн японы эрх зүй нь бичмэл хуульд үндаслагддаг боловч шүүхийн жишгийг үгүйсгэдэггүй, харин ч өргөнөөр хэрэглэж байна.

Шүүхийн жишгийг голчлон тулгуурласан эрх зүйн тогтолцоог нийтлэг эрх зүй гэх буюу статутад тулгуурласан эрх зүйн тогтолцоог эх газрын эрх зүй хэмээн тодорхойлох явдал нэгэнтүү түх болон ард хоёрч байгаа ёнаа үед Японы эрх зүйн тогтолцоог эх газрын, эсвэл нийтлэг эрх эзгийд тулгуурласан эрх зүйн тогтолцоо хэмээн хайрцаглан тодорхойлох боломжгүй. Тиймээс товчид нь дүгнэхэд Японы эрх зүйн тогтолцоо нь позитивизмээс анти-позитивизм руу шилжсэн гэж ерөнхийн хэлж болох юм.

Тухайн цаг хугацааны үед дэлхийн хөөрдүүгээр дайнаас эмне японы төр засаг позитивизмыг баримталах байсан болчвэй дайны дараа америкичдүйн анти-позитивист зарчмыг японд дэлгэрүүлэх болжээ.

Энэ нь орчин үед улам өргөжин тэлж байна гэж хэлж болно.

Дүгнэлт.

1. Японы эрх зүйн түүхээс харахад гадаад орны туршилгад тулгуурлан өөрийн орны хуулиудаа баталсан байна. Ингэдээ Франц, Герман, АНУ гэх мэт хэд хэдэн орны хуулийг авч хэрэглэжээ. Энэ нь манай улсын германы хуулиудыг, тэр дундаа Иргизийн хуулийг голчлон хуулбарлаж, үүний хажуугаар зарим еөвөрмөц онцлогтой хуулийг батлахдаа АНУ, Шинэ Зеланд, Австралии тэх мэт хөгжингүй орнуудын хуулийн туршилгыг судлахыг эрмэлзэж байгаа энэгийн байдалтай төстий харгажд байна.

2. Японы шүүхэд Х.Одагийн бичсэнчлэр obiter, ratio хөөр хоёул хэрэглэгдэж байгаа бол манай улсын шүүхэд ratio голчлон хэрэглэгдэж obiter ер хэрэглэгдэггүй гэж хэлж болно. Учир нь шүүхийн шийдвэрийг эмхтгэхдээ түүний дэлгэрэнгүй протокол буюу шүүхийн хэлсэн угийг манай улсад тэр бүр нарийвчлан онцолж, нийтэлж чаддагтүй.

3. Японд stare decisis хүчтэй хэрэгждэггүй бол манай улсад stare decisis Дээд шүүх тайлбар гаргасан тухайн тохиолдолд маш хүчтэй хэрэгждэг байна⁵.

4. Манай улсад позитивизм байр суурин хүчтэй олж авсанч гэлээ долийн бусад орны чиг хандлагыг даган анти-позитивизм руу ажаамаар шилжих эхэлэв тавигдаж байна гэж хэлж болно. Үүнд шүүхийн шийдвэрүүдийг нийтлэх ажил чухал үүрэг гүйцэтгэх байгаа юм.



¹ T. Nakano ed., *Hanrei no Yomikata* (How to read Cases), Tokyo 1986, P.142-147. See also Y. Higuchi, 'Hanrei no kogosuki-yukoku (On the Binding Force of Precedent)', in: Higuchi and M. Shimizu eds., *Nihon-koku Kenpo no Riron* (Theories of the Constitution of Japan), Tokyo 1987, P.684.

² supra note 3, 53.

³ Judgement of the Supreme Court, April 25, 1973 (*Keishu* 27-4-547: *Zen-norin keishokuho* case). Men Judgement of the Supreme Court, October 26, 1966 (*Keishu* 23-5-305: *Zentei-chuyu* case)

⁴ supra note 3, 53.

⁵ B. GUNBILEG, *LEGAL SYSTEM OF MONGOLIA*: 1) The terminology 'Khuuli' (statute), 'khuuli zui' (Rule of Statute) and how they influence Modern Mongolian law. 2) The interpretation of Supreme Court of Mongolia.. *Khuuli Deedieh Yos*, vol.3 (14), 2006. P.74-80.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн

Эвсэлд үл нэгдэх гэж июу вэ?

Тодорхой улс орнуудын нэгдэл, бүлэг зэвлэл тухайн улсын гадаад болдого юу? Энэ асуултад хариулахын тулд эвсэлд үл нэгдэх гах нар томъёот тайлбарласан олон утгыг авч үзэх нь хохистой. Эвсэлд үл нэгдэх хэмээх нар томъёо нь өөр өөр утга илэрхийлэх нь байдаг тухайлбал, Ханс Ж.Моргентай, Жеорж Лиска Лауренс В.Мартон зэрэг барууны эрдэмтэй төвийг сахих (neutralism), гэсэн угтаар тайлбарлаж байсан. Жорж Шварценбергер эвсэлд үл нэгдэхтэй ижил утгатай салан тусгаарлах (isolationism), ангид байх (non-commitment), төвийг сахих (neutralism), ног талыг баримтлах (unilateralism), үл оролцох (non-involvement) зэрэг нар томъёог хамааруулан тайлбарлаж байсан. Гэвч дээр дурдсан нар томъёо бур өөр өөрийн гэсэн мян чанартай. Энэ бүхий нарийвчлан тайлбарлах нь зүй ёсны юм. Салан тусгаарлах гэдэг нь хөндийн байх, болдого бол үл оролцох гэх ойлголт нь олон талт харилцаанд бусдаас хамарагчгүй байх болдого юм. Төвийг сахих гэдэг нь дайн байландаан үед дайтагч талуудтай баримтлах улс гурний улс төрийн болон эрх зүйн статусыг илэрхийдэг. Төвийг сахисан улс гурэн гэдэг нь ямар ч нехцелд хадгалийн байх улс төрийн статусай улс гурэн юм. (Швейцарийн улс бол төвийг сахисан улсын нэг жишиг мөн) Нэг талыг барьсан гэдэг нь учирч болох эрдэлдийг тооцсоны үндсан дээр болдого тодорхойлох тухайлбай, цемийн зэвсэгээ өөрийн санаачилгaaар устахаа зэрэг үйлдлийг оруулж болно. Үл оролцох гэх ойлголт нь өөр том гурнуудийн үзэл суртын тэмцлиээс ангид байх юм. Шварценбергер хэлэхдэй, эвсэлд үл нэгдэх болон дээр дурдсан бүйлгэлт нь ижил гэсэн уг биш бөгөөд үндсэндээ ялгатай юм.

Эвсэлд үл нэгдэх гэдэг бол ерөнхий утгар нь авч үзэх юм бол эвсэл, холбоонд үл нэгдэх бөгөөд нарийвчлан авч үзвэл цэргийн



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан

П.Баяр

эвслээс болгоомжлох болдого юм. Төвийг сахих гэдэг ойлголтой ихэд ойролцоо утгатай юм. Энэхүү хөдөр нь хоёулаа тусгайлан авч үзэх авас хүйтэн дайдж оролцохгүй байх ба ерөнхий угтаар нь авч үзэх авас бодитай дайдж үл оролцож гэсэн үндсан 2 шинхээрээ тестэй юм.

Зарим эрдэмтэн энэхүү хөдөр нэр томъёог сольж хяргалдэг боловч эвсэлд үл нэгдэх нь илүү өргөн угтатай юм. Учир нь энэхүү бодлогыг баримталх бүй улс бухий л нехцелд төвийг сахисан улс байх албаныг байдал будаа. Онцгой тохиолдолд дэлхий нийтийн харгат идэвхитэй оролцож болно. Эвсэлд үл нэгдэх нь гадаад болднын чиг хандлага болохын хувьд өөрчлөгджэй болно. Тийм ч учраас эвсэлд үл нэгдэх статусай орны хувьд засгийн газар нь өөрчлөгдхөн нь гол төлөв чиг хандлагахаа өөрчлөхэд хүргэдэг. Иймд шинэ засгийн газар эвсэлд үл нэгдэх болдого цаашид үргэлжлүүлэх эсхүү зогсоож буй талаараа мэддэгэл хийх ёстой байдал. 1977-1980 онд БНЭУ-д дээр дурдсантай адил жишиж Жаната намын нөхөнөөрөө тохиолдож байсан билээ. Эвсэлд үл нэгдэх нь төвийг сахих, төвийг сахисан статусай

адилгүй ба негеө талаар төвийг сахих нь олон улсын гэрээ хэлэлцээрийн үр дүнд батлгадаг. Төвийг сахих статус нь олон улсын гэрээ, хэлэлцээр нь өөрчлөгдөвүйг л бол засгийн газар солигдсон эсэхээс үл хамааран байнаа хэвээр байдаг.

Төвийг сахих болдого нь тодорхой нэг асуудлаас ангид байх болз эвсэлд үл нэгдэх нь ялгатай боловч нэгэн төрлийн зүйл нь юм. Эвсэлд үл нэгдэх нь зөвхөн нэг тодорхой зөрчилдөн, асуудлаас ангид байх бус мөн өрнөж буй олон улсын нехцел байдал тухайлбал хүйтэн дайнаас ангид байх зорилготой. Цэргийн эвсэл, холбоо хүйтэн дайны нехцелний бурдаулах авас эвсэлд үл нэгдэх статусай улсын хувьд эдгээр эвсэл холбоодос ангид байхыг аяндаа шаарддаг байна.

Нэгдэж эвсэхийн эсрэг эсэслэд үл нэгдэхийг сераугуулан тавих нь

Эвсэлд үл нэгдэхийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэн судлахын өмнө эвсэл, бүлгийн уламжлалт тогтолцоо бий болоход нөлөөлсөн хүчин зүйлийг судлан шинжлэх нь зүйтгэй юм. Эвсэл, бүлгийн тогтолцоо нь бие даасан тусгаар улсуудын хоорондын харилцаанд баримталж ирсан "олон улсын болдого гадэг бол чухал ашиг сонирхлоо бичилүүлэхийн тулд идэвхитэйгээр дурлан дээр эрх мэдээс хэрэгжүүлэхэд бэлтгэсэн олон тооны том жижиг нэгжүүдийн эрх мэдлийн төлөөх тэмцэлж л юм." гэсэн уламжлалт үзэл дээр үндэслэсэн юм.

Бүхий л засгийн газрыг бие даасан, энхийг эрхэмлэсэн байна гэж бодох авас эвсэлд нэгдэх нь зарим талаар сайн дүрүү бус болдог бөгөөд эвсэлд нэгдэн улс орнууд тухайн нехцелд эвсэл, холбоонд нэгдэн орохоос өөр сонголт байхгүй гэж үзсэн учраас нэгдэн орох болдог байна. Дийлэнх

тохиолдлод эвсэлд нэгдэн орохыг тулган хүлээгдэлтүй мөн түүнээс гарах үр дагавар ч биш юм. Нэгээ тавлар, бусад эрх мэдлийн хамгаалалтыг хүсэхэд өөрийн эрхгүй хүргэдэг нэхцэл байжлын бүрдэлд үндэстнүүдийн хариу үйлдэл нь эвсэлд нэгдэн орохор илэрдэг. 1945 оногийн хойш тийнхүү эвсэлд нэгдэн ороход хүргэж буй үндсэн хүчин зүйлүүдэд хүйтэн дайн (жижиг улсууд бусад том гүрнүүдэй эвсэн холбоотон болоход, узэл суртлын дайнд шууд татагдан оролцож байсан юм) дотоодын самуун (тухайтай, 2 өөр үзэл суртлыг баримтлагч зөрчилдэеент бүлгүүд Филиппин ба Малайзын удирдагч бүлэгт эвсэлд нэгдэн оросон байдаг), түлхэн унагаадаахас айх айдас (дотоодын хямралд гадаадын төвлөгөөчүд стратегийн болон улс төрийн давуу талыг олж авах зорилгоор оролцож дэмжих) одог.

Ж.В.Буртон үзэхээд эвсэлд нэгдэхийн шалтгаалт янз бүр байж болно, тэд үргэлж дандан тэргүүлэх үндэстнүүдийн түхирсан эрх мэдлийн төлөөх тэмцэл эскултээрхүү зөрчилтэй тэр бүр холбоогүй байдаг. Тээрээр цааши нь онцлоодоо, «Эвсэлд нэгдэх нь субъектив итгэл найдвараас үүдлэгтэй үндэстнүүдийн байдалтай холбоотой үрчилсан таамглагасаа ойлголт, урт хугацааны дайсанын болон хэдэн үе дамжин ирсэн айлас, доодынн үймэн самуун, үндэстнүүдийг салан тусгаарлах болдого эзргэс үүден гарч ирдэг, ихэнх тохиолдлаа гол эрх мэдлийн зөрчилдөвнөн нь бусад шантагын нүүн далдлахад халхавч болдог» гэсэн байдал.

